

International Scientific
Committee of Ozone Therapy



Мадриддйн Озон Терапийн Тунхагла

(3 дахь хэвлэл)



2020 оны 3 сарын 22

"Озон Терапийн практикт нэгдсэн стандарт тогтоохын төлөө"



ОЗОН ЭМЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ МАДРИДЫН ТУНХАГЛАЛ

(3 дахь хэвлэл)

ISCO3-ын албан ёсны баримт

Анхны хэвлэл № 01

Гаргасан огноо: 2010 оны зургаадугаар сарын 04-ны өдөр

ХОЁРДАХЬ ХЭВЛЭЛ № 02

Гаргасан огноо: 2015 оны зургаадугаар сарын 12-ны өдөр

ГУРАВДАХЬ ХЭВЛЭЛ № 03

Гаргасан огноо: 2020 оны тавдугаар сарын 14-ний өдөр

Хэвлэн нийтлэгчийн эрх (©) 2010, 2015, 2020.

ISCO3 (Озон эмчилгээний Олон Улсын Шинжлэх ухааны хороо)

Хуан Андресийн өргөн чөлөө 60, байршил 1 давхар, 28035, Мадрид (Испани).

Бүх эрх хуулиар хамгаалагдсан болно.

www.isco3.org info@isco3.org

Утас: +34 91 351 51 75 / +34 669 685 429

ISBN: 978-84-09-19932-7

ISNI: 0000 0004 8495 2016

Албан ёсны депозит: M-11427-2020

Албан ёсны хэл: Англи.

Эмхэтгэн боловсруулсан:

Адриана Шварц, Эмч, АУ доктор Грегорио

Мартинез Санчес, Эм зүйч, Ph.D.

Роберто Куинтеро, Хуульч **Хянан тохиолдуулсан:**

Уэйн Маккарти болон ISCO3-ын бусад гишүүд

Англи хэлнээс Монгол хэлрүү орчуулсан:

Суурь Жавзандулам M.D, АУ Магистр, Клиникийн профессор, ISCO3 гишүүн

Цэвээнмядаг Мөнхтуяа MD, УАУ Доктор

Сэрээнэн Зина M.D, АУ Магистр, Клиникийн профессор

Батсайхан Золзаяа M.D, УАУ-ны Доктор

Лундаажанцан Оюунэрдэнэ МЭУ-ны докторант

Баатархүүгийн Нямсүрэн Мал эмнэлгийн мэрэгжилтэн

Озон эмчилгээний Мадридын тунхаглалын (ISCO3, 2020 оны 3-дах хэвлэл) энэхүү албан

ёсны анхдагч эхийг Англи хэл дээр хэвлэн гаргасан болно.

График дизайн: Клара Баррачина. Эхийг

бэлтгэсэн: Ольга Морено.

Хэвлэн гаргасан: Графокс Импрента,. (Испани)



Озон эмчилгээний Олон улсын Шинжлэх ухааны Хороо

ОЗОН ЭМЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ МАДРИДЫН ТУНХАГЛАЛ

(2020 оны 3-дахь хэвлэл)

“Озон эмчилгээний эмнэл зүйн шалгуур үзүүлэлтүүдийн нэг мөр болгох”

ISCO3-ын албан ёсны баримт

Анхны хэвлэл: Анхны хэвлэл нь “Испанийн Озон Эмчилгээний Эмнэлгийн Эмч Мэргэжилтнүүдийн Нийгэмлэг” (AEPROMO)-ийн удирдлага, зохион байгуулалт дор 2010 оны 6-р сарын 4-нд Мадрид хот дахь Испанийн Эзэн Хааны Анагаахын Академид чуулсан “Озон эмчилгээний сургуулиудын олон улсын уулзалтаар батлагдсан.

Хоёр дахь хэвлэл нь Шүдний эмчилгээний хэсгийг нэмж шинэчилэн найруулсан хэвлэл: ISCO3 нь хоёрдахь хэвлэлийг 2015 оны 5-р сарын 10-ны өдөр баталсан байна. Тэгээд түүнийгээ Испанийн Озон Эмчилгээний Эмнэлгийн эмч Мэргэжилтнүүдийн Нийгэмлэг (AEPROMO)-гийн дэмжлэгтэйгээр ISCO3-ын удирдлага зохион байгуулалт дор Мадрид хотод 2015 оны 6-р сарын 12-нд Испанийн Эзэн Хааны Анагаахын Академаас зохион байгуулсан “Олон улсын уулзалт” дээр албан ёсоор танилцуулсан болно.

Гурав дахь хэвлэл нь Шүдний эмчилгээ болон Мал, амьтны эмчилгээний хэсгийг нэмж шинэчилэн найруулсан энэхүү хэвлэлийг ISCO3 (Озон Эмчилгээний Олон Улсын Шинжлэх Ухааны Хороо) **2020 оны 3-р сарын 22-ны өдөр** дэмжин гаргав.

Энэхүү баримтыг хэрхэн нийтлэх

Озон эмчилгээний Мадридын тунхаглал, ISCO3 (2020) Мадрид, 3 дахь хэвлэлийг www.isco3.org-д тавина. Озон эмчилгээний олон улсын Шинжлэх ухааны хороо.



ОЗОН ЭМЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ МАДРИДЫН ТУНХАГЛАЛ

Здахь хэвлэл, 2020

ISCO3-ын Албан ёсны баримт

Тунхаглалыг зохиогчид: (ISCO3-ын гишүүд):

1. Адриана Шварц, эмч, АУ-ны доктор.
2. Грегорио Мартинез Санчес, эм зүйч, PhD.
3. Фади Сабах, DDS, Хавсралт А: Озон эмчилгээг шүдний эмнэлэгт хэрэглэх.
4. Мерседес Эрнандес Авилес, D.V.M. Хавсралт В: Озоныг мал эмнэлэгт хэрэглэх.

Тунхаглал нь 2020 оны 3-р сарын 22-ны өдөр ISCO3-ын дараах гишүүдээр батлагдав.

Кармен Хелена Асеведо, M.D. Фройлан

Альварадо Гуэмес, M.D. Дарио Апуццо,

M.D.

Роберт Баннер, M.D.

Маурисио Карреньо Пеньяранда, M.D.

Хайме Улиес Качай Агурто, M.D.

Франсиско Убиратан Феррейра де Кампос, D.D.S.

Бернардино Клаво, M.D, PhD

Валери Дэвис, M.D.

Майкл К. Госсвейлер, D.D.S

Ана Гутьеррес Госсвейлер, D.D.S.

Мерседес Эрнандес Авилес, D.V.M.

Сюзанна Хамфрис, M.D.

Херардо Ибаньес Санчес, D.V.M.

Хайнц Конрад, M.D.

Виктор Леонель Льякса Саравиа, M.D.

Кевин Логан, M.D.

Грегорио Мартинес Санчес, эм зүйч, PhD Уэйн

Маккарти, N.D.

Мигель Анхель Монтойя Диас, M.D., PhD

Карлос Гоес Ногалес, DDS, PhD

Сергей Пертягин, M.D.

Мириам Портеро Фуэнтес, D.V.M., PhD Фади

Саббах, D.D.S.

Адриана Шварц, M.D. Магда

Сикейра, D.D.S. Роберто

Сикейра, D.V.M.

Роберто Кинтеро, хуульч, Улс төрийн ухааны доктор, Олон улсын харилцааны шинжээч, ISCO3-ын Хуулийн зөвлөх (ISCO3-ын гишүүн бус)



Мадридын тунхаглалын гурав дахь хэвлэлийг шинэчлэн гаргах ажилд бараг нэг жилийг зарцуулсан. ISCO3 2019 оны долоон сараас Озон эмчилгээний тухай мадридын тунхаглалыг шинэчлэх санаачлага, саналаа ирүүлэхийг хүссэн хүсэлтийг олон улсад илгээсэн билээ. Санал хүлээн авах эцсийн хугацаа нь 2019 оны 11-р сарын 30-ны өдөр байсан. Хүлээн авсан саналуудын үндсэн дээр эмхтгэн боловсруулсан ба тунхаглалын хэд хэдэн өөр хувилбаруудыг гаргаад түүнийгээ ISCO3-н гишүүдэд хэлэлцүүлэхээр илгээсэн билээ. Идэвхитэй хэлэлцүүлэг өрнүүлэн гаргасан саналууд болон засварыг оруулан ISCO3-н 27 гишүүн Тунхаглалын 3 дахь хэвлэлийг 2020 оны 3-р сарын 22-ны өдөр санал нэгтгэйгээр батласнаар энэхүү Тунхаглал нь Хорооны албан ёсны баримт болон гарсан билээ.

Энэхүү Тунхаглалыг шинэчлэх нөр их ажилд хувь нэмрээ оруулсан болон дэмжлэг үзүүлсэн бүгдэд ISCO3-н зүгээс талархалаа илэрхийлж байна

ISCO3 ГЭЖ ЯМАР БАЙГУУЛЛАГА ВЭ?

ISCO3 нь 2010 онд байгуулагдсан ашгийн бус шинжлэх ухааны нийгэмлэг бөгөөд түүний үйл ажиллагаа нь Испани улсын хуулиар зохицуулагдана.

ISCO3 нь озон эмчилгээний үндэсний болон олон улсын нийгэмлэг болон арилжааны байгууллагуудыг нэгтгэсэн анагаахын шинжлэх ухааны бие даасан, ашгийн бус байгууллага. Иймээс ISCO3-ын 27 гишүүд нь аль нэг үндэсний буюу олон улсын озон эмчилгээний нийгэмлэг, холбоо болон арилажааны байгууллагыг төлөөлдөггүй бөгөөд зөвхөн ISCO3-ын хүрээнд өөрсдийн үйл ажиллагаагаа явуулдаг болно.

ISCO3 нь гишүүдийн бүрэлдэхүүнээрээ дамжуулан олон улсын шинжлэх ухааны байгууллага болж ажиллах тодорхой зорилготойгоор байгуулагдсан бөгөөд түүний зөвлөмжүүд нь энэхүү эмчилгээг хийдэг бүх хүмүүст лавлах эх сурвалж болох ёстой.

Гишүүдийг 5 жилийн хугацаагаар сонгодог. ISCO3 эхлээд 2019 оны 7-р сараас озон эмчилгээ эрхэлдэг болон энэхүү эмчилгээтэй холбоотой ажилладаг олон улсын мэргэжилтнүүдэд шинэ гишүүн сонгох зар түгээсэн бөгөөд хугацаа нь 2019 оны 10-р сарын 31 –ны өдөр дуусах байлаа. Ирүүлсэн мэдэгдлүүдийн үндсэн дээр гишүүдийг 2020 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн 5 жилийн хугацаагаар сонгосон бөгөөд энэхүү хугацаа 2024 оны 12-р сарын 31-ний өдрөөр төгсгөл болох юм. Сонгогдсон шинэ гишүүд нь ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч болон эрдэмтэн нарийн бичгийн дарга нараас бүрддэг удирдах зөвлөлөө сонгосон болно.

ISCO3-ын үндсэн зорилгууд

Озон эмчилгээний арга тус бүрийн шинжлэх ухааны болон анагаахын үнэ цэнэ, зүй зохист хэрэглээг тодорхойлох, түүнчлэн хэрэглээний буруу үйлдлийг таслан зогсоох, болзошгүй алдаа дутагдлаас сэргийлэх, эмчилгээний стандартчилагдсан аргуудыг бий болгоход оршино.

Шинжлэх ухааны бодит судалгаанууд дээр үндэслэн озон эмчилгээний арга тус бүрийг стандартчилна.

Энэхүү зорилгуудаа биелүүлэхээр ISCO3 дараах 3 зорилтыг дэвшүүлсэн болно:

- Озон эмчилгээний тухай Мадридын тунхаглалыг батлан хэвлүүлэх: Анхны хэвлэл 2010 онд гарсан бол шинэчлэсэн дараагийн хэвлэлүүдийг 2015, 2020 онуудад гаргав.
- Озон эмчилгээтэй холбоотой төрөл бүрийн өгүүлүүдийг хэвлэн нийтлэх, батлан гаргах



- Озон эмчилгээний талаар хэвлэн гаргасан бүх өгүүлэл, нийтлэлүүдийг багтаасан ISCO3-ын *Озон эмчилгээний олон улсын номын санг*²³ бий болгох, Энэхүү номын сан нь Интернет орчинд нээлттэй, үнэ төлбөргүй бөгөөд тогтмол шинэчлэгдэж байх болно.

СОНОРДУУЛГА

ISCO3-ын бүхий л баримт бичгүүд нь (Озон эмчилгээний тухай Мадридын тунхаглал ч багтана) зөвлөгөө, зөвлөмж бөгөөд озон эмчилгээг эрхэлж буй мэргэжилтнүүдэд зөвлөмж, лавлагааны эх үүсвэр болох болно. Эдгээр нь заавал мөрдөх зүйл биш бөгөөд озоны эмчилгээг эрхлэгч эмч бүр ISCO3-ын зөвлөмжийг ашиглах эсэхийгээ өөрийн клиникийн туршлага, үзэл баримтлалаараа шийдэж байвал зохино. Озон Эмчилгээний Олон Улсын Ш/У-ны Хорооноос/ISCO3/ эрхлэн гаргадаг зүйлүүд тухайлвал үйл ажиллагаа, аюулгүй байдал, хэрэглээний дүрэм болон бусад бүх техникийн баримтууд нь ISCO3-ийн нэрийн дор байдаг бөгөөд эдгээрийн өгөгдлүүдийг ISCO3-ын гишүүдболон бусад хүмүүсийн мэдээлэл, туршлага, судалгааны үр дүнгийн нийтлэлүүд зэрэг найдвартай эх үүсвэрүүдээс авсан болно.

ISCO3-ын бичиг баримтад дурдсан зөвлөмж болон мэдээллийг ашигласнаас гарах үр дүнд ямар нэгэн хариуцлага хүлээхгүй бөгөөд гарах үр дүнг хариуцахгүй болно.

ISCO3 өөрийн зөвлөмжийг ашиглахад болон ISCO3-ын гаргасан аливаа зөвлөмж, мэдээллүүдийг хувь хүн болон аливаа нэгэн байгууллага зөв, буруугаар тайлбарлахад ямар нэгэн хяналт тавьдаггүй болно. Иймээс дээрх үйлдлүүдэд ISCO3 ямар нэг хариуцлага хүлээхгүй.

ISCO3 нь нийтлэлүүдээ байнга шинэчлэдэг бөгөөд харилцагчиддаа хамгийн сүүлчийн хувилбаруудыг ашиглахыг санал болгодог.



ОЗОН ЭМЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ МАДРИДЫН ТУНХАГЛАЛ

3 дахь хэвлэл, 2020.

ISCO3-ын албан ёсны баримт бичиг

Анх 1781 онд Голландын эмч Мартинус ван Марум озоныг нээж 1840 онд немец химич Христиан Фридрих Шонбейн озоныг нийлэгжүүлэн гаргаж авснаас хойш дэлхийн олон оронд түүнийг эмчилгээнд хэрэглэх нь ихээхэн өсөхийн хирээр өвчтөнүүдэд ашиг тус нь харагдаж энэ нь **анагаахын салбарын мэргэжилтнүүдийн анхаарлыг татаж эхэлсэн** бөгөөд тэд озоны үйлчилгээ, эмчилгээний давуу тал юунд оршиж байгаа нь хамгийн сонирхолтой асуудал болж судлаж байна. 2010 оны Мадридийн тунхаглалын анхны хэвлэлийг баталснаас хойш хамтын хүчин чармайлтын үрээр эмчилгээний олон ололт гарсан ч озоны эмч нарыг нэгтгэж озон эмчилгээний арга, аргачлалуудыг хэрэглээнд ашиглан дэлгэрүүлэх нь амаргүй асуудал байлаа. Учир нь одоо ч эрүүлийг хамгаалахын хүрээнд ч озоныг эмчилгээнд ашиглахад эсэргүүцэлтэй тулгарч байгаа нь бидэнд озон эмчилгээг ашиглах хууль эрх зүйн талбарт илүү нягт зохицуулалт шаардлагатайг харуулж байна.

Дэлхийн олон улсад озон эмчилгээний клиникийн өмнөх судалгаанууд болон клиникийн туршилтууд шинжлэх ухааны нарийн дэгийн дагуу хийгдэж байгаа бөгөөд эдгээр туршилтуудын үр дүн нь озон эмчилгээний **практик хэрэглээг баталж байна**.

Олон оронд хийгдэж буй озон эмчилгээний сөрөг нөлөө, удамшлын материалд нөлөөлөх байдал зэргийн талаарх клиникийн өмнөх судалгааны үр дүнг үндэслэн үзэхэд эмчилгээний энэхүү арга нь озоны тунгийн өргөн хүрээнд аюулгүй болох нь батлагдаж байна.

Илүү их мэдээллийг ISCO3-ын албан баримтууд (Озон эмчилгээ ба түүний Шинжлэх ухааны үндэслэл¹, Ozone therapy and it's Scientific Foundations.¹)-аас олж болно.

Төрөл бүрийн саад бэрхшээл байгаа ч озоны судалгааны явц болон хэрэглээнд ахиц дэвшил гарсаар байна. Гэвч озоны нийгэмлэгүүдийн болон судлаачдын байнгын бөгөөд үндсэн бэрхшээл нь шинжлэх ухааны зайлшгүй шаардлагатай шинжилгээ, судалгаанд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийн байнгын дутмагшил байсаар байгаад оршино.

Эмнэлзүйн аюулгүй байдлыг стандартчилсан протоколын дагуу тодорхой зорилго тавин нэгдсэн аргачлалаар эмчилгээний баталгаатай байдлыг дээд зэргээр ханган ажиллах нь туйлын чухал юм. Тодорхой ахиц дэвшил гарч байгаа ч эрүүл мэндийн байгууллагуудын хүрээнд оршсоор байгаа эмчилгээний ялгаатай байдлыг нэг стандарттай болгох, хэрэглэж буй шилдэг арга аргачлал, үйлчилгээг цаашид улам хөгжүүлэх, зүй бус ашиглалт, эмчилгээний буруу арга аргачлалуудтай тэмцэх, шилдэг аргуудыг нэвтрүүлэх шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй байна.

Одоогийн ба Одоогийн байдлаар доор нэр дурьдсан 13 улс озон эмчилгээний аргачлалдаа анхаарч баталгаажуулан ашиглаж байгааг **тэмдэглэхэд таатай байна**. Үүнд: Грек (1991, 2014) Украин (2001, 2014); Италийн Ломбарди (2003), Эмилия-Романья (2007), Марче (2009), засаг захиргааны төв Лазлио (1996, 2003); БНХАУ (2005); ОХУ (2005, 2007); Испанийн өөртөө засах нийгэмлэгүүдээс 15-д нь (2007 – 2012 онуудын хооронд) мөн улсын нийгмийн эрүүл мэндийн төвийн 20 төвд озон эмчилгээг нэвтрүүлсэн; Куба (2009, 2015); Оманы Султанат (2010); АНЭУ-н Дубайд (2011); Португал (2013 – 2018 онуудад); Турк (2014); Бразил, шүдний эмчилгээнд 2015 онд, эрүүл мэндийн салбарт 2018 онд, Мексик, Нуэва-Леон муж (2018).



Тиймээс бусад улсууд ч энэхүү туршлагыг дагана гэдэгт итгэж байна. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг ISCO3-н албан ёсны баримтаас авч болно: *Озон эмчилгээ ба эрх зүйн зохицуулалт.Хэрэглээний дүн шинжилгээ*²

Мадридийн тунхаглалын зохиогч бөгөөд эзэмшигч болох Озон Эмчилгээний Олон Улсын Шинжлэх Ухааны Хороо (ISCO3) улс орон бүрийн озон эмчилгээний эмч нарт хандан энэхүү тунхаглалыг шинэчлэн өөрчлөх талаарх санал хүсэлтээ ирүүлэхийг уриалсан юм. ISCO3, хорооны гишүүд нь тэднээс ирүүлсэн олон тооны саналуудыг нэгтгэн судлаад 2020 оны 3-р сарын 22-нд энэхүү тунхаглалыг гаргасан билээ. Өргөн хүрээтэй санал солилцолт

болон дараагийн өөрчлөлтүүдийг хийхдээ озон эмчилгээний тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, сайн гарын авлагатай болох үйлсэд оролцох **боломжийг тэдэнд олгохыг зорьсон юм.**

Бидний бэлтгэсэн Тунхаглалын энэхүү хувилбар нь (3 дахь хэвлэл) дэлхийн озон эмчилгээний салбарын ололт амжилт, өвчтөнд чанартай үйлчилгээ үзүүлэх зөв аргачлалыг тусгасан бөгөөд озон эмчилгээний мэргэжилтнүүдийн бүх санал хүсэлтийг **илэрхийлсэн гэж үзэж байна.**

Озон Эмчилгээний Олон Улсын Шинжлэх Ухааны Хороо (ISCO3)-ноос хийсэн дүгнэлтүүд

Нэг. Нэгдүгээрт, "Озоныг эмчилгээнд хэрэглэх хүрээ, хязгаар болон энэхүү тунхаглалын хавсралтад нарийвчлан тусгасан хоёр нэмэлтийг батлах

Хоёр. Озон хэрэглээний явцад илэрч байгаа эерэг, сөрөг тохиолдлуудын талаарх мэдлэг, мэдээлэл, судалгаа туршлагуудыг аль болох сайн солилцуулах замаар энэ эмчилгээнээс ирээдүйд хүртэх ашиг тусын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх. Шинжилгээ, судалгааны үр дүнг анагаах ухааны сэтгүүлүүдэд нийтлэхэд дэмжлэг үзүүлэх, ISCO3-ын Озон эмчилгээний олон улсын номын сангийн³ (Ozone therapy International Library³) интернет орчинд төлбөргүйгээр нэвтрэх хэсэгт цуглуулсан шинжлэх ухааны хэлэлцүүлгүүдийг судлах.

Гурав. Озон эмчилгээний эмнэлзүйн хяналт туршилт сайжирснаар түүний аюулгүй байдал, үр нөлөө ашиг тус нь улам тодрох учраас энэ чиглэлд ажиллах эрүүл мэндийн судлаачдын бүтээлч хүчин чармайлтыг дэмжих.

Дөрөв. Эмнэлзүйн зөв сонголтын дагуу өвчтөн нэг бүрт тохируулан төрөл бүрээр ашиглахуйц чанартай, шинэлэг байлгах үүднээс хандсан, стандартчилагдсан үйлдлийн журмыг бүтээж хөгжүүлэх ажлыг үргэлжлүүлэх

Тав. Одоогоор хүрээд байгаа үр дүнг тусгасан, хүрч болохуйц бодит зорилт дэвшүүлдэг, хөгжилд дэвшил авчирхуйц зөвлөмжүүдийг гаргадаг, ололт амжилтаа хуваалцдаг, озон эмчилгээг ойлгон гүнзгийрүүлэхэд чиглэсэн судалгаануудыг хөхүүлэн дэмжихэд чиглэсэн эрдэм шинжилгээний хурал чуулгануудыг системтэйгээр зохион байгуулахад анхаарах. Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрхүйц найруулан нэг мөр болгосон шалгууртай болох.

Зургаа. Озон эмчилгээг одоогоор албан ёсоор зөвшөөрөөгүй байгаа орнуудын ижил төстэй холбоодын ажлыг дэмжин озон эмчилгээнд албан ёсны зөвшөөрөл олгуулахад туслах.



Долоо. Өвчтөнд үзүүлэх озон эмчилгээний чанар үр нөлөөг дээшлүүлэх, практик аргачлалыг стандарчлах зорилгоор Озон эмчилгээний онолын болон практик сургалтуудыг системтэйгээр зохион байгуулахыг дэмжих.

Найм. ISCO3 мэтийн олон улсад зөвшөөрөгдсөн байгууллагуудын хянан тохиолдуулсан, заавар зөвлөмжийн дагуу ижил төрлийн аргачлал, стандартын шаардлагад нийцсэн сургалт, дамжааг дэмжих.⁴

Озон Эмчилгээний Олон Улсын Шинжлэх Ухааны Хороо (ISCO3)-оос гаргасан ЗӨВЛӨМЖ

Озон эмчилгээний Мадридын тунхаглал (3 дахь хэвлэл, 2020) – ийн **Озоныг эмчилгээнд хэрэглэх хүрээ хязгаар, түүний нэмэлт хавсралт** -д тодорхой заасан озоны тун хэмжээ нь озон эмчилгээний эмч нарт аюулгүй бөгөөд үр дүнтэй хамгийн бага гаж нөлөө үзүүлэх тун хэмжээг зааж өгсөн болно.

Озоныг эмчилгээнд хэрэглэх хүрээ хязгаар, түүний нэмэлт хоёр хавсралт нь олон орны эмч, эрдэмтдийн олон жилийн судалгаа шинжилгээ, клиник туршилтуудын цогц үр дүнгийн товчилсон илэрхийлэл болно.

Озон Эмчилгээний Олон Улсын Шинжлэх ухааны Хороо (ISCO3) – ийн ТАЛАРХАЛ

Доктор Велио Боччи (2019 онд таалал төгссөн) болон **Доктор Набиль Масуф** (2015 онд таалал төгссөн) нарт озон эмчилгээний үүсэл хөгжил, судалгаа, мэдээлэл болон өвчтөнүүдэд үзүүлсэн тусламж зэрэгт түүний оруулсан үнэтэй хувь нэмэрт тань бид **гүн талархал** илэрхийлж байна. Тэрээр манай анхдагчдын нэг гэдгээрээ түүхэнд үлдэх болно.

“Озон эмчилгээний Олон улсын уулзалт”-ыг санаачлан зохион байгуулж үзүүлэлтүүдийг нэгтгэсэн баримт бичиг гаргах зайлшгүй шаардлагатай байгааг ойлгон Мадридын 2010 оны анхны тунхаглалын үзэл баримтлалыг санаачилсан доктор Адриана Шварцад **талархал илэрхийлье**. Доктор **Адриана Шварц**, Доктор **Грегорио Мартинес Санчес** нарын итгэл зүтгэл нөр их хөдөлмөрийн ачаар Озон эмчилгээний Мадридын тунхаглалыг батлан түүний хоёр, гурав дах хэвлэлийг шинэчлэн гаргасан болохоор энэхүү нөр их ажлын манлайлагчид нь болж байна.

“Озон эмчилгээний Мадридын тунхаглал (Здахь хэвлэл)”-ыг хэвлэн нийтлэх үйлсэд материал техникийн болон зохион байгуулалт, удирдлагын туслалцаа үзүүлсэн “**Испанийн Озон Эмчилгээний Эмнэлгийн Мэргэжилтнүүдийн Нийгэмлэг (AEPROMO)**” – д **гүн талархал илэрхийлье**.

Ишлэл авсан хэвлэлүүд:

1. ISCO3. Ozone-Therapy and its Scientific Foundations. <http://www.isco3.org/>. 2012. <http://www.isco3.org/>. Accessed on 13/08/2019.
2. ISCO3. Ozone Therapy and Legislation - Roberto Quintero, ISCO3 legal advisor; and Adriana Schwartz, ISCO3 secretary. 66 pages. Approved by ISCO3 on November 18, 2012. 2nd updated and extended edition May 20, 2015. <https://isco3.org/officialdocs/#5> Accessed on 16/01/2020.
3. ISCO3. Worldwide Ozone-therapy (O₃) Data Reference. https://www.zotero.org/groups/isco3_ozone/items. Accessed on 11/03/2020.
4. ISCO3. Learning Methodology Instructions and Perfection in Ozone Therapy for Medical Doctors. <http://www.isco3.org/>.org 2015. Accessed on 11/03/2020.
5. Posicionamiento de la Sociedad Española del Dolor [SED] Frente a la Ozonoterapia en el Tratamiento del Dolor. Diciembre 2018. Anexo 1: Hospitales públicos en los que hay constancia del uso de la oonoterapia.

ОЗОН ЭМЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ МАДРИДЫН ТУНХАГЛАЛ

(3 дахь хэвлэл, 2020)

“Озон эмчилгээний практик дах шалгууруудыг нэг мөр болгох нь”

ISCO3-ын албан ёсны баримт



ОЗОН ЭМЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ МАДРИДЫН ТУНХАГЛАЛЫН НЭМЭЛТ ХЭСГҮҮД ба ХАВСРАЛТ
НЬ
(3 дахь хэвлэл)-ЫН
ТҮҮНИЙ САЛШГҮЙ ХЭСЭГ ЮМ.

Озон эмчилгээний олон улсын Шинжлэх ухааны хороо (ISCO3)-ноос 2020 оны 03-р сарын 22-ны өдөр батлав.

ИНДЕКС

ОЗОНЫГ ЭМЧИЛГЭЭНД ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ ХЯЗГАА Р

1. ЭМЧИЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ.....	17
2. ОЗОН ЭМЧИЛГЭЭНИЙ (О _{3x}) ҮНДСЭН ЗАРЧИМ OZONE THERAPY (О _{3x}) BASIC PRINCIPLES.....	23
.....	23
Озон эмчилгээ хийхийн өмнө анхаарах ёстой хоёр үндсэн зарчим байдаг. Үүнд.....	23
2.1 Эсрэг заалт <i>Contraindications</i>	23
2.2 Анхааруулга <i>Warning</i>	23
2.3 Озоны харилцан үйлчлэл <i>Interaction with Ozone</i>	24
2.4 Гаж нөлөө <i>Adverse Effects</i>	24
2.5 Хордлого.....	26
2.6 Хүүхдэд шулуун гэдсээр озон хийх арга.....	26
3. ОЗОН ЭМЧИЛГЭЭ ХИЙХ ҮНДСЭН АРГА ЗАМУУД.....	27
3.1 Санал болгож буй системийн эмчилгээний аргууд.....	27
3.2 Хэсэг газрын үйлчилгээ бүхий аргууд.....	33
3.2.2 Багана нурууны булчинд тарих.....	33
3.2.13 Нүдний эмчилгээ.....	36
3.3 Аюулгүй байдлыг хангах үүднээс хэрэглэхийг зөвлөдөггүй аргууд.....	40
3.4 ХОРИГЛОДОГ АРГУУД.....	41
3.5 Бүрэн зөвшилцөлд хүрээгүй хэрэглээний замууд.....	41
4. ОЗОН ЭМЧИЛГЭЭ ХИЙХЭД ТОХИРОМЖТОЙ ӨВЧИН ЭМГЭГҮҮД.....	43
4.1 А Түвшинд хамрагдах өвчнүүд.....	43
4.3 С Түвшинд хамрагдах өвчнүүд.....	45
5. ЭМЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ.....	46
5.1 Үндсэн шаардлага.....	48
5.2 Озон эмчилгээний сургалт явуулах үндсэн дүрэм.....	48
References.....	49
1. ӨМНӨХ ҮГ/PREFACE/.....	70
2. ҮНДСЭН ЗАРЧМУУД /BASIC PRINCIPLES/.....	71
3. ШҮДНИЙ ОЗОНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ НОТОЛГООД СУУРИЛСАН АРГАЧЛАЛУУДЫН АНГИЛАЛ.....	75
4. ЭМНЭЛ ЗҮЙН ЕРӨНХИЙ УДИРДАМЖУУД.....	77



<i>References</i>	84
ХАВСРАЛТ В	87
МАЛ ЭМНЭЛГИЙН САЛБАРТ ОЗОН ЭМЧИЛГЭЭ АШИГЛАХ ЭМНЭЛЗҮЙН АРГАЧЛАЛУУД	87
<i>References</i>	101

ТОВЧИЛСОН ҮГ ACRONYMS

ACD-A: Цитрат декстрозын антикоагулянт, уусмал-
ACE: Ангиотензин хувирагч энзим
ADL: Өдөр тутмын үйл ажиллагаа
AE: Сөрөг үр нөлөө
AMP: 5"- аденозинмонофосфат
AMPK: AMP-идэвхит протеинкиназа
b.w: Биеийн жин
CBV: Эргэлдэх цусны эмжээ
CE: Европын нийгэмлэг
COPD: Уушигны архаг бронхит
CT: Компьютертомограф
DIV: Венийн судсанд озоныг шууд тарих
DOAC: Шууд уух антикоагулянт
DPG: 2,3-дифосфоглицерат
EBOO: Цусыг биеийн гаднах төхөөрөмжөөр озонжуулах
EBM: Нотолгоонд суурилсан эмчилгээ
ESA: Эритропозидэвхижүүлэгч
EU: Европын холбоо
FDA: АНУ-ын эм, хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн хяналтын газар
FIO: Итали улсын озон эмчилгээний холбоо
G6PD: Глюкоз-6-фосфатдигидрогеназа
GED: Хийн солиоцооны төхөөрөмж
HBO3: Олон замт өндөр даралтат арга
HIV-AIDS: хүний дархлал хомсдолын вирус-олдмол дархлал хомсдолын хам шинж
HNE: 4-гидрокси-2,3-транснональ
INR: Олон Улсын стандартын харьцаа
IO3A: Озоны Олон Улсын Холбоо
IP: Хэвлийн хөндий
MAH: Үндсэн цустай озонжуулах эмчилгээ/MAH/
MiAH: Бага хэмжээний цус озонжуулах эмчилгээ/MiAH/
MOG: Эмчилгээний озон генератор
NOAC: Цус шингэлэгч шинэ бэлдмэлүүд уухаар
NIH: Эрүүл мэндийн үндэсний институт /АНУ/
O₃/O₂: Эмнэлгийн озон
O₃SS: Озонжуулсан давсны уусмал
O₃x: Озон эмчилгээ
PTFE: Политетрафторэтилен
PV: Хэт ислийн хэмжээ
PVDF: Пойвинилдендифторид
RIO₃: Шулуун гэдсээр озон нэвчүүлэх
ROS: Хүчилтөрөгчийн идэвхитэй хэлбэрүүд
SH: Сульфгидрильн бүлэг
µg/Nml: Микрограмм/Нормаль миллилитр
USP: АНУ-ын фармакопей
UV: Хэт ягаан туяа
VTD: Венийн судасны бөглөрөлт өвчин



1. ЭМЧИЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ

Озон эмчилгээ(Озх) гэдэг нь тусгай зориулалтын эмнэлгийн генераторын тусламжтайгаар хүчилтөрөгч озоны хольцыг (95% - 99.95% хүчилтөрөгч ба 0.05% - 5% озон) гарган авч олон төрлийн өвчнүүдийн үед эмчилгээний төрөл бүрийн протокол, аргуудыг ашиглан эмчлэх нэмэлт эмчилгээний арга юм¹. Хэрэглэх аргачлалаас хамаараад озон нь 1) шууд исэлдүүлэх 2) шууд бус замаар нөлөөллийг үзүүлдэг. Харин түүний хариу урвал нь нуклей хүчлийн дамжуулах механизмын хувилбар болох Nrf2- NFKB уургуудын нийлэгжих дохионоос хамаардаг.²⁻⁴ Ийнхүү озон эмчилгээний тунгийн үзэл баримтлал нь түүний биед дасан зохицохчанар дээр суурилдаг. Энэ нь үрэвсэлт үеийн болон түүний эсрэг хариу урвалын тэнцвэрт байдлыг зохицуулахад чухал юм. Сүүлийн үед озон эмчилгээг эмнэлзүйн практикт нэвтрүүлэх талаар хийсэн эмнэлзүйн 251 туршилт судалгаа, санамсаргүй хяналтат 169 туршилт судалгаа, Анагаах ухаанд озоны хэрэглээг дэмжих 24 системчилсэн тойм судалгаа, 18 мета-анализ судалгаа байна. Үүнээс гадна АНУ-ын Үндэсний эрүүл мэндийн хүрээлэнгийн клиник судалгааны мэдээллийн санд /ЕЕУУ/ “озон эмчилгээ”-ний сэдвээр 37 судалгаа бүртгэгдсэн байна.⁵

Озон эмчилгээ нь орлуулах эмчилгээ биш (not an alternative) харин туслах буюу нэмэлт эмчилгээ (complementary) юм. Озон эмчилгээ нь нэмэлт эмчилгээ буюу аллопатик эмийн оронд биш харин хамт буюу зэрэгцүүлэн хийвэл зохилтой болно. Нэмэлт ба альтернатив хоёрын ялгааг ойлгох нь озоны эмчилгээний эмчийн хувьд маш чухал юм. Озон эмчилгээг хэрэглэх нь бусад аллопатик/тусгай эрхтэн системийг эмчлэхэд зориулсан эм бэлдмэлүүд/ эмчилгээ, тухайлбал эмийн эмчилгээ, мэс заслын процедуруудад хавсардаг, харин тэдгээрийг орлохгүй.

АНУ-ын Эрүүл мэндийн хүрээлэнгийн (NIH) дэргэдэх Нэгдсэн Эрүүл Мэндийн Төв (NCCIH) нь туслах болон орлуулах эмчилгээний ялгааг тодорхой заасан байдаг. Эдгээр хандлагыг тайлбарлахдаа хүмүүс ихэвчлэн "алтернатив" ба "complement" буюу туслах ба орлуулах гэсэн ойлголтыг хольж хэрэглэдэг боловч энэ хоёр нэр томъёо нь өөр өөр утгатай. Тухайлбал хэрэв эмчилгээний үндсэн бус аргууд нь /conventional/ уламжлалт буюу үндсэн эмчилгээтэйгээ хамт хэрэглэвэл нэмэлт гэж үздэг. Гэтэл үндсэн бус практик нь уламжлалт буюу үндсэн эмчилгээний оронд ашиглагдаж байвал орлуулах гэж үздэг.⁶

АНУ-ын Үндэсний Эрүүл Мэндийн Хүрээлэнгийн дэргэдэх Хавдар судлалын үндэсний хүрээлэн мөн ялгааг тодорхойлсон байдаг. Альтернатив эмчилгээ: "Стандарт эмчилгээний оронд хэрэглэдэг зүйлүүд (...) Жишээлбэл, хорт хавдрын эсрэг эмийн оронд тусгай хоол хэрэглэж болно."⁷ Нэмэлт нь "Стандарт эмчилгээтэй зэрэгцүүлэн хэрэглэдэг гэхдээ стандарт гэж тооцогддоггүй Жишээ нь, зүү эмчилгээг зарим эмтэй хослуулан хэрэглэж хавдрын өвдөлт, дотор муухайрах, бөөлжихийг багасгахад тусалдаг.⁸

Европын холбооноос баталдаг уламжлалт /стандарт/ бус эмийн тухай хууль тогтоомжийг Европын парламент хэлэлцэж, нэмэлт болон орлуулах эмчилгээ хоёрын ялгааг тогтоожээ: "Ийнхүү эмийн эсвэл мэс заслын эмчилгээ нь нэгнийгээ орлож байгаа нь алтернатив харин өөр нэг эмчилгээнд нэмэлтээр хэрэглэгдэж байгаа нь нэмэлт юм. Энэхүү гол ялгааг үндэслэн “3.[Европ Парламент] уламжлалт бус эмчилгээний төрлийн тухай Европын хууль тогтоомжийг боловсруулахдаа Комиссоос уламжлалт бус эмчилгээнүүд мөн түүнчлэн уламжлалт болон хэрэглэгддэг эмчилгээг орлодог алтернатив эмчилгээнүүдийг тодорхой болгохыг хүссэн байдаг.⁹



Озон эмчилгээний хувьд төрөл бүрийн өвчний эмчилгээнд нэмэлт, туслах, хөнгөвчлөх зорилгоор ашиглагдана. Озон эмчилгээ нь уламжлалт эмчилгээнд нэмэлт болон эдгэрэлтийг хөнгөвчлөх шинэ технологийн аргуудын нэг хэсэг юм. Энэ бол эмчийн эмнэлгийн практик дахь өөр нэг арга хэрэгсэл юм.

Озоны эмчилгээний эмч. Энэ эмчилгээг хийдэг эмчийг озоны эмчилгээний эмч гэж нэрлэдэг. Терапевт гэдэг үг нь Грек хэлнээс (therapeutes) гаралтай бөгөөд therapeuein гэсэн үйл үгээс бүрддэг бөгөөд асрах, анхаарал халамж тавих, хөнгөвчлөх, гэсэн утгатай. Иймээс эмч гэдэг үг нь өвчин эмчлэх үйлсэд өөрийгөө зориулж байгаа хүнийг хэлдэг ба энэ тохиолдолд хүчилтөрөгч-озоны хольцыг ашиглаж байна. Озон эмчилгээний хүрээ хязгаарыг өөрийн мэргэжлийн хүрээгээр хязгаарлах ёстой. Өөрөөр хэлбэл: хүний их эмч нар хүний эмчилгээ эсвэл эмнэлзүйн туршилтыг хариуцах, шүдний эмч амны хөндийн өвчин, эмгэгийг эмчлэх, малын эмч нар, хүнээс бусад амьтдын өвчин, эмгэг, гэмтлийг эмчлэх гэх мэт өөрсдийн мэргэжлийн чиглэлд л ажиллах ёстой. Биохимич, эм зүйч, биологич нар молекул, эмнэлзүйн өмнөх болон эмнэлзүйн судалгаанд оролцоно. Харин эмнэлзүйн судалгааг өвчтөн дээр туршихад хүрвэл тэр нь эмчийн үүрэг байх болно. Сувилагч, техникийн ажилтнууд холбогдох эмчийн зааврын дагуу ажиллана. Озон эмчилгээ нь эмнэлгийн гардан үйлдэл учраас зөвхөн эмч эмнэлгийн мэргэжилтнүүд хийх ёстой.

Эмнэлгийн озоны генератор (MOG). Европын холбооны хэмжээнд озоны генераторууд нь эмнэлгийн багаж тоног төхөөрөмжийн IIb ангилалд багтдаг. Эмнэлгийн бусад тоног төхөөрөмжтэй адил стандарт гэрчилгээтэй баталгаатай генератор байх ба Зөвлөлийн удирдамжийн 93/42/ЕЕСед заасан ерөнхий дүрмийг баримталж CE чанарын тэмдэгийг заавал авсан байх ёстой. Ийнхүү худалдан авагчид "CE тохирлын мэдүүлэг"-ийг баталгаажуулахыг зөвлөж байна. Бусад улс орнуудын хувьд озоны аппаратыг худалдан авагч нь эмнэлгийн хэрэгсэлийг оруулахтай холбоо бүхий л төрийн байгууллагаас олгосон зөвшөөрөлтэй эсэхийг шалгах нь маш чухал байдаг. Дэлгэрэнгүй мэдээллийг эмнэлгийн озоны аппарат хэрэгсэл авахаар төлөвлөж буй эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан ISCO3 удирдамж, зөвлөмжөөс үзэх боломжтой. Мадрид, 2019. Озоны олон улсын шинжлэх ухааны хороо эмчилгээ. ISCO3 Guidelines and Recommendations for Medical Professionals Planning to acquire a Medical Ozone Generator. Madrid, 2019. International Scientific Committee of Ozone Therapy.¹⁰

Мөн озон гарган авах генератораа /MOG/ эрүүл мэндийн чанарын гэрчилгээтэй баталгаатай эмнэлгийн зориулалттай цэвэр 99.5%-ийн хүчилтөрөгчийн цилиндртэй /баллонтой/ холбосон байх ёстой. Үйлдвэрлэлийн зориулалт бүхий хүчилтөрөгчийн цилиндрийн хувьд түүний эрүүл ахуй, дүүргэх хурд, савны дотоод чийгшил, ариутгал зэрэг нь стандартын шаардлагаас ялгаатай тул эмнэлгийн зориулалтаар ашиглах боломжгүй юм. Өрөөний агаарыг ашигладаг машинууд, тухайлвал хүчилтөрөгч өтгөрүүлэгч төхөөрөмж нь озоны эмчилгээнд ашиглагдахгүй, учир нь энэ нь озоноос өөр бодис үйлдвэрлэх магадлалтай.

MOG нь озоны концентрацийг нарийн хэмжих ёстой (1 мкг/мл-80 мкг/мл), ба хүчилтөрөгч-озоны жигд холимог үүсгэх ёстой. мкг/-ээр илэрхийлсэн концентраци NmL бөгөөд алдаа нь $\pm 10\%$ -иас бага буюу тэнцүү байх ёстой. Үүнээс өөр бодис байх ёсгүй. Үйлдвэрлэсэн хийн хольцод зөвхөн O_2 ба O_3 байж болно.

Эмнэлгийн шаардлага хангасан хүчилтөрөгч (O_2) нь тухайн орон нутгийн фармакопейн эмийн чанарын стандартад нийцсэн байх ёстой. Хэрэв орон нутгийн фармакопей байхгүй бол фармакопейн лавлагаа нь: Европ Фармакопей,¹¹ АНУ-ын фармакопей,¹² Японы фармакопей¹³ эсвэл Орос зохицуулалт ГОСТ 5583-78 (Үйлдвэрлэлийн болон эмнэлгийн хүчилтөрөгч)¹⁴ гэсэн нэрээр байдаг.



Озоны эмчилгээний хувьд шалгуур үзүүлэлтүүд нь нэг л байх ёстой. Эмийн чанарын эдгээр зохицуулалтуудаас харахад озоны генератор (MOG) чанарын баталгаатай байх ёстой¹³. Тэгснээрээ зөвхөн эмчилгээний зориулалттай, өөрөөр хэлбэл, хүчилтөрөгч-озоны жигд хольцыг үүсгэнэ. Хүчилтөрөгч – Озоны энэ хольцийн концентраци 1 мкг/мл ба 80 мкг/мл байна. Зөвхөн эмнэлгийн зориулалт бүхий хүчилтөрөгч /O₂/ болон озон/O₃/-ны холимог нь өөр ямар нэг хий болон бодисын агууламжгүй байх ёстой бөгөөд үүнийг баталгаажуулахын тулд озоны агууламж болон озон үүсгэгч хэрэгсэлд хяналтын тохируулгыг жилд нэг удаа тогтмол хийх ёстой.

Концентраци. Озоны хийн агууламжийн хэмжүүрийг баталгаатай байлгахад температур ба даралт. 1 атм даралт (760 ммМУБ, 1.10325 бар, болон температур 0°C; 273.15 K) стандартыг хангах ёстой. Эдгээр нөхцлийг хангах "Олон улсын стандарт нөхцөл" ба "озоны нормчлогдсон концентраци" гэсэн нэгжийг мкг/мл-ээр илэрхийлнэ¹. Энэ нь Олон улсын озоны холбооноос хүлээн зөвшөөрөгдсөн цорын ганц нэгж юм. IO3A.¹⁵ Энэ мкг/мл-ээр илэрхийлэгдсэн концентрацийн хазайлт нь ±10% -иас ихгүй байх ёстой.

Тун хэмжээ ба нөлөөлийн хамаарал. Озон эмчилгээний үед физиологийн бага тун нь эсийн дотор чухал үүрэг гүйцэтгэн эмчилгээний нөлөө үзүүлдэг гэсэн үндэслэл дээр суурилдаг.^{16,17} Озоны тун болон нөлөөний хамаарал нь дасан зохицох (hormetic) шинж чанартай байдаг. Озоны тунгийн нөлөө болон хариу /hermetic/ урвал нь таамаглал биш харин судалгаа болон эмнэлзүйн туршилтаар нотлогдсон байдаг. Озоны медиатрууд болох H₂O₂ ба 4-гидрокси-2,3-трансноненал, HNE-зэрэг нь нуклейны хүчин зүйлтэй харилцан үйлчлэлцэж, улмаар эмчилгээний хариу урвал үүсдэг нь одоо шинжлэх ухааны судалгаагаар баттай нотлогдсон.^{2,3,19} Озоны бага тун нь молекулын исэлдэлтийг бууруулагч болох нь тогтоогдсон Nrf2/Keap1 эсвэл NF-kB/IκB зэргийг дасан зохицох хариу урвал болгон биохимийн замыг өөрчлөх боломжтой. Ийм байдлаар бага тун нь эсийн амьдрах чадварыг өөрчлөхгүйгээр эсийн хамгаалалт, нуклейны транскрипцийг идэвхжүүлдэг ба харин эсрэгээрээ өндөр тун нь генотоксик байж болно.^{18,20-22} Озон эмчилгээний тунг тохируулаагүйн улмаас эд эсийн үхжил,^{18,20} хорт хавдрын өдөөлт хүртэл ноцтой гаж нөлөөнүүд озоны архаг хордлого буюу өндөр тунтай²¹ холбоотой гарах магадлалтай.

Озон эмчилгээний эмнэлзүйн нотолгоог дэмжих үйл ажиллагааны янз бүрийн механизмуудыг молекулын түвшинд тодорхойлсон байдаг.²¹ Энэхүү баримт бичигт нэгтгэсэн мэдээлэл нь ISCO3 Озоны эмчилгээний олон улсын номын санд үнэ төлбөргүйгээр үзэж болох 3000 гаруй шинжлэх ухааны ном, нийтлэлд үндэслэсэн болно ISCO3 Ozone Therapy International Library²³.

Озоны эмчилгээний үр дүнгүй, хортой концентраци гэж байдаг. Ер нь баталгаатай бөгөөд өргөн хэрэглээний тун бол 10 мкг/Нмл эсвэл 50 мкг/Нмл ба түүнээс бага концентраци нь эмчилгээний үр нөлөөтэй байдаг ба аюулгүй байдаг. Тиймээс одоо эмчилгээний озоны энэ тунг системийн эмчилгээний аргуудын үед хүлээн зөвшөөрч байна. Тухайлвал үндсэн цустай озонжуулах эмчилгээ (МАН), озонжуулсан давсны уусмал (O3SS), шулуун гэдсээр хийх (RIO3), үтрээний озон гэх мэт системийн чанартай эмчилгээний нэг курсын нийт тун 5.0-6.0 мг байх ба концентраци 10 мкг/Нмл- 50 мкг/Нмл хүртэл хооронд хэлбэлздэг.²²

Озоны нийт тун нь хийн эзэлхүүнийг (мл) озоны агууламжаар (мкг/Нмл) үржүүлсэнтэй тэнцүү байна (Тун = Эзлэхүүн х Концентраци). Тунг биеийн жин кг-аар биш харин тунгаар өгдөг учраас тунгийн хамааралтай хариу урвал болон концентрацийг озоны мкг/Нмл эсвэл мг/НЛ-ээр илэрхийлж болно.²⁴ Доктор Боччигийн хэлснээр "багаас эхэлж, удаан яв" гэдэг зарчмыг ягштал баримтлан тунг нэмэгдүүлэх нь зүйтэй.²⁵



Биеийн жинд үндэслэн озоны тунг тооцоолох судалгаа үргэлжилж байна. Үйл ажиллагааны механизмын дагуу эмчилгээний бүх тунг гурван төрөлд хуваадаг (Хүснэгт-1)

а) Нам тун: Эдгээр тун нь дархлааг сайжруулах /immunomodulatory/ үйлчилгээтэй бөгөөд дархлааны системийг дэмжих шаардлагатай өвчнүүдийн үед хэрэглэнэ. Жишээлбэл, хорт хавдар, өндөр настан, тамир тэнхээ султай өвчтнүүд гэх мэт.

б) Дундаж тун: Эдгээр нь дархлааг сайжруулдаг бөгөөд антиоксидант ферментийн хамгаалалтын системийг идэвхжүүлдэг /immunomodulatory and antioxidant enzyme defense system/. Эдгээр нь чихрийн шижин, атеросклероз, уушигны архаг бөглөрөлт өвчин (COPD), Паркинсоны хам шинж Альцгеймер, хөгшрөлтийн деменци зэрэг архаг дегенератив өвчинд хамгийн их тустай байдаг.

в) Өндөр тун: Эдгээр тун нь аутоиммун өвчнүүдийн үед үүсэх механизмыг дарангуйлах нөлөө үзүүлнэ. /Inhibitory effect/ жишээ нь ревматоид артрит, чонон хөрвөс зэрэг аутоиммун өвчний үед үүсдэг механизмыг дарангуйлдаг. Мөн яр шархлаа, бохирдсон шарх гэмтэл, мөн озонжуулсан тос, ус бэлтгэхэд ашигладаг.

Хэрэглэгдэх материал. Хэрэглэгдэх бүх материал нь нэг удаагийн, озонд тэсвэртэй байх ёстой, жишээлбэл: шил, силикон, зэвэрдэггүй ган 316, фторполимер хуванцар, PTFE политетрафторэтилен (Тефлон®), PVDF поливинилиден дифторид (Купар®), фтор нүүрстөрөгч (Viton®), лабораторийн шил, титан ба поликарбонат.

Үйлчлэлийн механизм. Озон эмчилгээг хэсэг газар хийсэн тохиолдолд түүний үйлчлэл нь шууд исэлдэлт байдаг. Харин озоны системийн арга нь үндсэндээ дараахь механизм дээр суурилдаг.

Redox био зохицуулагч. Озоныг бага тунгаар системийн байдлаар хийхэд тэр нь биомолекулуудтай урвалд орсноор хоёр дахь медиаторуудыг (жишээлбэл, устөрөгчийн хэт исэл ба 4-гидроксиалкенил) үүсгэдэг.² Хоёр дахь дохио илгээгч -SH үлдэгдлийг исэлдүүлэх замаар дохионы дамжуулалтыг өдөөдөг. Харин түүний үр дүн нь Nrf2 эсвэл NFκB зэрэг нуклейны хүчлийн дамжуулалтын механизмын модуляц болон уургийн нийлэгжилтийг зохицуулж Үүний үр дүнд Nrf2 антиоксидантуудын зохицуулга эсвэл NFκB-ээр дамжуулан иммуномодуляци болдог.²⁻⁴ Эмнэлзүйн болон эмнэлзүйн өмнөх судалгаар молекулын түвшинд энэ механизм батлагдсан байдаг.²⁶⁻³⁰

Өвдөлт намдааж: Хэсэг газрын озон тарилга нь дараахь молекул механизмаар өвдөлтийг бууруулдаг: Өвдөлтийн медиатор эсвэл өвдөлтийн рецепторыг³¹ шууд исэлдүүлэх,³¹ пуринэрги рецептор болох P2X3 ба P2X7³²-ийг хориглох; caspase замыг хувиргах,³³ LC3B ба Beclin1-ийг хориглох замаар эд эсийн аутофаги-ийг зогсоодог ба Caspase 3, фосфодиэстераза 2A ба NFκB p65 дохиог идэвхгүйжүүлэх замаар эсийн эвдрэлийг (апоптоз) зогсоодог. 5'-аденозин монофосфат (AMP) болон идэвхтэй киназа (AMPK) уургыг идэвхжүүлдэг.³⁵

Эд эсийн хүчилтөрөгчжилт: Озоны системийн арга нь гипокси болон ишемийн синдромуудад ашигтай. Озон нь цусны урсгалыг сайжруулж, гемоглобиноос эд эсэд O₂ ялгаруулж, өөрчлөгдсөн гемостатик-гемореологийн үзүүлэлтүүдийг сайжруулахад хүргэдэг.³⁶⁻³⁸ Холбогдох механизмууд нь хэсэгчлэн 2,3 дифосфоглицератын (DPG) замыг нэмэгдүүлдэг.³⁹

Хүснэгт 1. Озоны хамгийн түгээмэл хэрэглэгддэг арга аргачлалын озоны концентраци/эзлэхүүний зааварчилгаа, удирдамж (1А хүснэгт - хэсэг газрын эмчилгээнд; 1Б хүснэгт, Системийн эмчилгээнд).

Хүснэгт 1 А. Хэсэг газрын эмчилгээнд

Хэсэг газрын эмчилгээнд хамгийн өргөн хэрэглэгддэг аргууд					
Хийх арга	O ₃ /O ₂	Тун хэмжээ			Анхаарах зүйл
		Нам	Дундаж	Өндөр	
Чихэнд	C.(µg/NmL)	4	10	20	2 минутын турш 50 мл-ийг тариураар аажим шахаж хийнэ.
	V.(ml)	50	50	50	
	D(mg)	0.2	0.5	1	
Уутаар	C.(µg/NmL)	30-20	50-40	80-60	20-30 минут хийх ба эмчилгээнээс өмнө талбайг чийглэсэн байна
	V.(ml)	Уутны хэмжээгээр			
	D(mg)	Уутны эзэлхүүнээр			
Нуруунд	C.(µg/NmL)	10	15	20	ISCO3(2014) ⁴⁰ болон ISCO (2016) ⁴¹ -гаас дэлгэрүүлж харна уу
	V.(ml)	5-20			
	D(µg)	50-200	75-300	100-400	
Нурууны дискэнд хийх	C.(µg/NmL)	25	30	35	Хүзүү болон нурууны баганад 3-5 мл озон тарина.
	V.(ml)	10	10	10	
	D(µg)	250	300	350	
Арьсан дор	C.(µg/NmL)	5	8	10	Хамгийн ихдээ 100 мл-нэг удаад, целлюлит арилгах зорилгоор бол 200 мл хийж болно.
	V.(ml)	1-2			
	D(µg)	5-10	8-16	10-20	
Гарын арьсан дор нэвчүүлэх/бээлийн арга	C.(µg/NmL)	20	10	5	7 хоногт 2 удаа өвдөлт намдтал буюу ойролцоогоор 6-нь нэг курс болно. ⁴²
	V.(ml)	10-40			
	D(µg)	50-200	100-400	200-800	
Мөр, өвдөг, түнх, тохой, шагайн үенд хийх тарилга	C.(µg/NmL)	5	10	15-20	ISCO3(2014) ⁴⁰ Ozone in Non- Rheumatic Locomotor System Pathologies, -c тодруулж харах.
	V.(ml)	5-20			
	D.(µg)	25-100	50-200	75-700 300-400	

Жич: Эмчилгээнд зөвлөдөггүй арга зам: Амьсгалаар/үнэрлэж огт болохгүй/ хордох эрсдэл нь их учраас, дэлгэрэнгүйг хараарай/⁴³

Сануулахад: C-концентрац; V-эзлэхүүн; D- тун 1mg=1000 микрограм

Хүснэгт.1В. Системийн арга аргачлалууд

Системийн эмчилгээнд хамгийн өргөн хэрэглэгддэг аргууд					
Хийх аргууд	O3/O2	Тун хэмжээ			Анхаарах зүйлүүд
		Нам	Дундаж	Өндөр	
Их цустай озонжуула арга (МАН)	C.(µg/NmL)	10-20	20-30	35-40	Зарим тохиолдолд /дархлааны өвчнүүд болон вирусын халдварууд/ 50-60 микрограм хүртэл тооцоологдон хийгдэх нь байдаг. Тэгснээрээ цитокиныг маш их өдөөх нөлөөтэй. Харин авах цусны нийт хэмжээ нь биеийн жинг нь 1,2 –оор үржүүлсэнтэй тэнцүү байж болно. ⁴⁴
	V.(ml)	50-100			
	D(µg)	0.5-1.0-1.0-2.0	1.0-1.5 2.0-3.0	1.75-2.0 3.5-4.0	
Бага цустай озонжуул арга	C.(µg/NmL)	5-10	15-20	30-40	Судаснаас 5 мл цусыг ижил хэмжээний озон хүчилтөрөгчийн холимог агуулсан 20-ын шприцээр соруулан авч булчинд тархна. ⁴⁵
	V.(ml)	5			
	D(µg)	25-50	75-100	150-200	
Үтрээгээр	C.(µg/NmL)	10-15	20-25	30-35	Нэг минутанд 0.1-0.2л хурдаар тоохон 10 минутын турш угаана. ⁴⁶
	V.(L)	1-2			
	D(µg)	10-15 20-30	20-25 40-50	30-35 60-70	
Шулуун гэдсээр нэвчүүлэх (RIO3)	C.(µg/NmL)	10-15	20-25	25-30	Хамгийн их концентрац буюу 40 микрограм/мл нь энтероцитийг гэмтээж болзошгүй учир зөвхөн Ulcerative hemarrhagic colitis үед эхний тунг 60-70 мкг/мл 50 мл аваад тунг тогтмол концентрацаа багасгана. ⁴⁷
	V.(ml)	100	150	200	
	D(mg)	1.0-1.5	3.0-3.75	5.0-6.0	
Биеийн гадна цус озонжуула (EBOO)	C.(µg/NmL)	0.1	0,25	0,4	30-35 мл/минут хийх нь зохимжтой ⁴⁸
	V.(ml)	18			
	D(µg)	1,8	4.5	7.2	
Сауна	C.(µg/NmL)	5	8	10	20-30 минут, 10-15 минут озонтой, дараа нь 10-15 минут ууранд суух халуун нь 40-45 градус ⁴⁹
	V.(ml)	Сауны загвар төрлөөс			
Биологийн идэвхт цэгүүдээр хатгалт хийх	C.(µg/NmL)	6	7	9	Арьсан дотор эсвэл арьсан дор тарьж болно. Triger point болохоор булчинд өвдөлттэй цэг бүрт тарьж болно. ⁵⁰
	V.(ml)	0.1-0.3			
	D(µg)	0.6-1.8	0.7-2.1	0.9-2.7	
Озонжуулсан давсны уусмал (O3SS)	C.(µg/NmL)	0,4	0,8	2	Судсаар хийхийн өмнө 10 минут озонжуулаад дараа нь судсаар хийх явцдаа тогтмол озонжуулна. Хийх явцдаа озоны тунг тогтмол байхад анхаарах.
	V.(ml)	200			
	D(µg) б/ж-нд	1	2	5	

Жич: Хэсэг газар хийсэн эмчилгээ бүх биед буюу системд нөлөөлөх нь байдаг.⁴⁹

Эмчилгээнд зөвлөдөггүй арга зам: хураагуур судсанд тарих, өндөр даралтат озон, хэвлийн гялтан дотор, өндөр тунгаар, олон газар гэх мэт. Сануулахад: С-концентрац, V-эзлэхүүн, б/ж -биеийн жин, D-доз, тун 1mg нь 1000 mkg

2. ОЗОН ЭМЧИЛГЭЭНИЙ (O_{3x}) ҮНДСЭН ЗАРЧИМ OZONE THERAPY (O_{3x}) BASIC PRINCIPLES

Озон эмчилгээ хийхийн өмнө анхаарах ёстой хоёр үндсэн зарчим байдаг. Үүнд:

- a) Юуны өмнө ямар ч хор хөнөөл учруулахгүй байх
- b) Тунгаа шатлана: Үргэлж бага тунгаар эхэлж, аажмаар нэмэгдүүлнэ.^{25,51}

Харин халдварлагдсан шарх, гэмтэл зэргийн үед эсрэгээр нь хэрэглэнэ. Энэ тохиолдолд, өндөр концентрацитай эхэлж, өвчтөний байдал сайжрахын хэрээр бууруулна. Дэлгэрэнгүйг хүснэгт 1-ээс үзнэ үү. Озоны өндөр концентраци нь чухал биш. Энэ нь бүх эмийн нэгэн адил байдаг.

2.1 Эсрэг заалт **Contraindications**

Озон эмчилгээний системийн аргуудын эсрэг заалтууд

1. Глюкоз-6-фосфат. дегидрогеназын дутагдал (фавизм, цочмог цус задралын цус багадалт).
2. Хорт гипертиреодизм ийн нөхцөл байдал.
3. Тромбоцитопени 50,000-аас бага, цусны бүлэгнэлтийн ноцтой эмгэгүүд.
4. Зүрх судасны тогтолцооны хүнд хэлбэрийн тогтворгүй байдал.
5. Согтууруулах ундааны цочмог хордлого.
6. Зүрхний булчингийн цочмог шигдээс.
7. Их хэмжээний болон цочмог цус алдалт.
8. Таталттай байдлын үед.
9. Гемохроматоз.
10. Зэс, төмрийн эмчилгээ хийлгэж буй өвчтөнүүдэд судсаар хийх гэх мэт.

* Глюкоз 6 фосфат дегидрогеназын (G6PD) дутагдлын тархалт нь угсаатны бүлгүүдэд өөр өөр байдаг. Америк (3.4%), Европ (3.9%), Номхон далайн бүс нутагт (2.9%), Африк (7.5%), Ойрхи Дорнод (6.0%), Ази (4.7%).⁵² Озон эмчилгээ эхлэхийн өмнө хүндрэлээс урьдчилан сэргийлж G6PD-ийн шинжилгээ хийлгэхийг зөвлөж байна.

2.2 Анхааруулга **Warning**

Жирэмслэлт. Озон эмчилгээ нь жирэмслэлтгүй холбоотой төрөл бүрийн өвчин, тухайлбал: гестоз,⁵³⁻⁵⁵ ихсийн дутагдал,⁵⁶ ургийн өсөлтийн саатал,⁵⁷ умайн хүзүүний эктопи,⁵⁸ преэклампси зэрэг өвчнийг эмчлэхэд сайн үр дүнтэй байдаг. Жирэмсний эхний гурван сар (0-13 долоо хоног), үр хөврөл, ургийн хөгжлийн чухал үе бөгөөд байгалийн шалгаралын үе учраас болгоомжлох нь зүйтэй юм.

Тэмцээн уралдааны үед: Озон эмчилгээ хийх системийн аргууд нь 2,3 дифосфоглицератын³⁹ хэмжээг нэмэгдүүлэх замаар булчинг хүчилтөрөгчжүүлж эрчимжүүлдэг. Уралдаан тэмцээний зорилгоор системчилсэн озоны эмчилгээг хийхдээ хариуцсан эмчээс зөвшөөрөл авсан байх ёстой.



“2009 онд нэвтрүүлсэн Гематологийн загвартнь ESA [эритропоэзийг өдөөгч агент] болон аливаа хэлбэрийн тухайлвал цус сэлбэх, гардан ажилбаруудын үед хүчилтөрөгчийг нь нэмэгдүүлж өгдөг. Гематологийн модулын шинжилгээнд тамирчны цусны дээжинд цусны допингийн биомаркер дүн шинжилгээ хийдэг.”⁶¹

Антикоагулянт эмчилгээ хийлгэж буй өвчтөн. Озон ба антикоагулянтыг системчилсэн байдлаар тохируулан хэрэглэх нь коагуляцын явцыг өөрчилдөг⁶², Ингэснээрээ Олон улсын нормчлогдсон харьцааг (INR) тогтмол хянадаг. Хэрэв шинэ шууд нөлөө бүхий уудаг антикоагулянт (ACOD) эсвэл шинэ уудаг антикоагулянтууд (NACO) венийн тромбозмболийн өвчинд (VTD) хэрэглэдэг байгаа бол тэдгээр нь озонтой бүрэн нийцдэг болохоор INR хяналт шаарддаггүй. Үүнд: (Ривароксабан (арилжааны нэр: Xarelto®), Дабигатран (Pradaxa®), Аликсабан (Eliquis®), Эдоксабан (Lixiana®)).⁶³

2.3 Озоны харилцан үйлчлэл Interaction with Ozone

Озоноор эмчлэх явцад антиоксидант нэмэлтүүд (жишээлбэл, витамин С, Е витамин) хэрэглэж болно. Гэсэн хэдий ч эдгээр нэгдлүүд цусанд өндөр концентрацитай байвал озоны исэлдүүлэгч бодис болох үйл ажиллагаа, эмчилгээний явцад саад болдог. Тиймээс эмчилгээний явцад уухаар витамин эсвэл антиоксидантыг өгч болохгүй. Зөвхөн озон эмчилгээ хийлгэхээс өмнө эсвэл дараа нь өгөх ёстой. Дарангуйлах нөлөө нь тодорхой антиоксидант бүрийн био хүртээмжээс хамаарна. Витамин С, глутатион зэрэг антиоксидант судсаар тарих эмчилгээг озон эмчилгээ хийлгэхээс өмнө болон эмчилгээний үед хэрэглэхгүй, зөвхөн озоны эмчилгээний дараа хэрэглэхийг зөвлөж байна.

Хомеопатийн бүтээгдэхүүн, прокаин, магнийн сульфат, глутатион, витамин С гэх мэт эмийг озонтой хольж хэрэглэхээс зайлсхийх; эсвэл озоны системийн аргуудтай зэрэгцүүлж хэрэглэхгүй байх, жишээлбэл, озонжуулсан давсны уусмал (O_3SS), (МАН) үндсэн цустай озон эмчилгээ зэргийн үед тэдгээрийг нэг шил болон тариурт хольж хийхгүй байх. Учир нь озон нь тэдгээрийг исэлдүүлж, идэвхгүйжүүлэх эсвэл хортой нэгдлүүдийг үүсгэдэг. Озон нь АСЕ хориглогчийн нөлөөг нэмэгдүүлдэг. Кумадин/гепарин зэрэг цусны бүлэгнэлтийн эсрэг эмчилгээ хийлгэж буй өвчтөнүүдэд озоны эмчилгээг INR-ийн хяналтан дор хийх ёстой. Зэс, төмрийн эмчилгээ хийлгэж буй өвчтөнүүд озоны эмчилгээ хийж болохгүй.

Бусад исэлдэлтийн үйлчилгээнд (U.V., H_2O_2 гэх мэт) синергетик нөлөө үзүүлдэг. Хоёр ба түүнээс дээш исэлдэлтийн эмчилгээг нэг дор хийхгүй байхыг бид зөвлөдөг. Энэ нь өвчтөний исэлдэлтийн стрессийг нэмэгдүүлнэ. Лазер эмчилгээ, соронзон эмчилгээ, зүүний эмчилгээ, диатерми, физик эмчилгээ зэрэг нь хамт хэрэглэгдэж болох талтай.

2.4 Гаж нөлөө Adverse Effects

Мэдээлэгдээд байгаа гаж нөлөөнүүдийн ихэнх нь, хийх арга, аргачлал, тун хэмжээг буруу хэрэглэснээс үүдэлтэй байна.

Гаж нөлөөг (АЕ) 2010 оны NIH шалгуурын дагуу ангилж үзвэл.⁶⁴

2.4.1 1-зэрэг Хөнгөн зэргийн гаж нөлөө

Ямар нэг арга хэмжээ шаардлагагүй бөгөөд шинж тэмдэггүй болон үл мэдэг эмнэл зүйн шинж тэмдэг ажиглагдаж болно.

- Зарим өвчтөнүүд хэсэг газар түр зуур, бага зэрэг халуун оргилоо, хийж байх үед бага зэрэг өвдлөө гэдэг.⁶⁵
- Озон хийсэн талд нэвчдэс үүссэн тохиолдол нэг.⁶⁶
- Дөрвөн хүнд озон хийсний дараа хэл уруул загатнасан. Өөр гурван хүн озонжуулсан цус давтан хийх үед дотор муухайрч, эвгүй амтагдсан, нэг өвчтөн эмчилгээний үед амьсгаадсан.^{68, 69}
- Артерийн ишемитэй арьсны хоёрдогч улайлттай 15 өвчтөнд биеийн гадна цусыг хүчилтөрөгчөөс озоноор баяжуулан эргүүлж хийхэд эйфория ажиглагдсан.⁶⁹

2.4.2 Дунд зэргийн гаж нөлөө

Бага зэргийн болон хэсэг газрын өөрчлөлтүүд ажиглагдсан. Ямар нэгэн эмчилгээ шаардахгүй ч өдөр тутмын үйл ажиллагаануудыг багасгах (ADL)

- Озон кортикостеройд эмчилгээ хийлгэж байсан хүмүүсээс хөлийн мэдэрхүй буурч эхэлсэн ба хоёр цагийн дараа намдсан.⁷⁰
- Озоны тарилга хийлгэж байсан таван тарианы дараа нуруу болон хөлний өвдөлт мэдрэгдсэн боловч удалгүй аажимдаа зүгээр болсон. Найман хүнд озон хийсний дараа нүд загатнаж амьсгал өөрчлөгдсөн.⁷¹
- Шулуун гэдсээр озон хийсэн тохиолдолд гэдэс дүүрч өтгөн хатаж байсан тохиолдол гарсан.⁶⁹

2.4.3 Хүнд зэргийн гаж нөлөө

Амь насанд аюултай биш боловч эрүүл мэндэд нөлөөлсөн эмнэлэгт хэвтсэн, эмчилгээний хоног удааширсан, хөдөлмөрийн чадвар алдсан, өөртөө үйлчлэх нь хязгаарлагдсан гэх мэт.

- Нурууны ёзоорт харвалт.⁷²
- Нэг тохиолдолд нүдний шиллэгт харвалт өгсөн.⁷³
- Нэг тохиолдолд тархины зөөлөн бүрхүүл цочирсон.⁷⁴
- Гурван тохиолдолд вирусын гепатит өгсөн.⁷⁵
- Нурууны нөхөн сэргээх эмчилгээний хэд хэдэн тохиолдолд халдварын хүндрэл гарсан.⁷⁶ Багана нуруунд буглаа хоёрдогчоор үүссэн/chemonucleolysis-ийн диск дотор хийх үед/⁷⁸ МАН эмчилгээг хурдан хийх үед судасны агшилт илэрсэн.
- Ууц нурууны өвдөлт эмчилгээнээс идээт хүндрэл гарсан.⁷⁹
- Хүзүүний дискийн эмчилгээнээс spondylodiscitis үүссэн.⁸⁰

- Нурууны ивэрхийд эпидурал тарилга хийсний дараа толгой хүчтэй өвдөж Pneumocephalus илэрсэн тохиолдол.⁸¹
- Хүзүүний дискийн ивэрхийн эмчилгээний үед эпидурал хатгалтаас цахилгаанд цохиулах мэт хүчтэй толгойн өвдөлт үүссэн.⁸²
- Intraforaminal тарилга хийх үед яс болон зөөлөн эдийн завсар хатуу наалдац үүсч тогтсон⁸³

2.4.4 4-р зэрэг

Амь насанд аюултай, яаралтай тусламж шаардлагатай хүндрэлүүд

- Периганглион венийн зангилаанд хийн эмболиин улмаас нугаламын артерийг хамарсан хэсэг газрын өвдөлт хэдэн минут өгч байсан бөгөөд хэдэн өдрийн дараа намдсан нэг тохиолдол илэрсэн.⁸⁴
- Диск дотор тарилгын улмаас нуруу нугас болон зүрхэнд инфаркт өгсөн нэг тохиолдол байна.⁸⁵
- Синкопын нэг тохиолдол илэрсэн Сэргэснийх нь дараа багана нурууны ойролцоох озон тарилгын дараа зүүн 6-р мэдрэл саажин хөдөлж чадахгүй ярьж чадахгүй, тал саажилт үүссэн байсныг мэдсэн.⁸⁶
- Тархины хатуу хальс дор хийсэн тарилгаас үүдэн зүрх уушигны зогсолт болон пневмоэнцефалит илэрсэн.⁸⁷
- МАН эмчилгээний дараа зүрхний инфаркт гарч байсан.⁸⁸
- Озон эмчилгээний дараа цус хомсдлын ишеми үүсч байсан.⁸⁹
- МАН эмчилгээний дараа бөөрний архаг үрэвсэлтэй, даралт ихтэй өвчтөнд болсон тохиолдол байна.⁹⁰
- Диск дотор хийх явцад хараа түр зуур алдагдсан тохиолдол гарсан байна.⁸⁹

2.4.5 5-р зэрэг

Гаж нөлөөний улмаас нас барсан тохиолдол

- Судсаар озон шууд хийж (DIV) байх үед хийн эмболи болж нас барсан 4 тохиолдол байна.⁹¹⁻⁹³
- Псириозтой өвчтөнд МАН эмчилгээ хийж байх үед нас баралт нэг гарсан байна.⁹⁴
- Нурууны дискийн эмчилгээ хийж байх явцад үжил гарч нас барсан нэг тохиолдол байна.⁹⁵

2.5 Хордлого

Озоныг хэзээч үнэрлэх юмуу амьсгалын замаар авч болохгүй бөгөөд энэ нь хориглогдсон аргуудын нэг. Озон эчилгээ нь хүснэгт-1-ийн дагуу зөв арга аргачлалаар, зөв тун хэмжээгээр мэргэшсэн эмч мэргэжилтнүүд зөв эмнэлзүйн протокол ашиглан хийж байгаа тохиолдолд ямар нэгэн аюулгүй эмчилгээ. Эмчилгээний гаж нөлөө болон үхэл нь зөвхөн эмчилгээг буруу хийснээс үүдэлтэй болно.

2.6 Хүүхдэд шулуун гэдсээр озон хийх арга

Хүүхдэд системийн аргаар хийхдээ зөвхөн шулуун гэдсээр нэвчүүлэх аргыг сонгоно.

- Озон эмчилгээний тун тухайн хүний исэлдэх урвалын түвшинболон өвчин эмгэгээс шалтгаална./Хүснэгт 2 А/
- Хийх хэмжээний хувьд бол харин наснаас шалтгаалдаг. (Хүснэгт 2В).
- Шулуун гэдсэнд озон хийхэд зориулагдсан гуурсны үзүүрийг (1-2) см хошногоны амсраар шургуулна.⁴⁷

Хүснэгт 2. Хүүхдэд шулуун гэдсээр озон шимэгдүүлэх тун хэмжээ

Хүснэгт 2А. Исэлдэлтийн стрессийг харгалзан тэр дагуу хийх

Эмчилгээ хийх хугацаа 7 хоногоор	Концентраци О ₃ (µg/NmL)		
	Исэлдэлтийн стресс		
	Бага	Дунд	Өндөр
1-р долоо хоног	20	15	10
2-р долоо хоног	25	20	15
3-р долоо хоног	30	25	20
4-р долоо хоног	35	30	25

Хүснэгт 2 Б. Өвчтний насанд харгалзуулан хийн эзлэхүүний хэмжээг тогтоох

Өвчтний нас	Хийн эзлэхүүн (мл)
28 өдөр -11 сар	15-20 мл
1-3 нас	20-35 мл
3-10 нас	40-75 мл
11-15 нас	75-120 мл

Таван удаагийн эмчилгээ бүрт тун хэмжээг нь өөрчилнө. Эхний жил 4-5 сар тутамд 15-20 удаа хийнэ. Дараа нь өвчтний биеийн байдлаас шалтгаалан 2 дахь жилд хэрхэн хийх тун хэмжээг тогтооно.

3. ОЗОН ЭМЧИЛГЭЭ ХИЙХ ҮНДСЭН АРГА ЗАМУУД

Эмнэлгийн озоныг хэсэг газрын болон парентераль замаар хийж болно. Эмчилгээний үр дүнг нэмэгдүүлэхийн тулд озоны хэрэглээний янз бүрийн аргыг хослуулан эсвэл дангаар нь ашиглаж болно.

3.1 Санал болгож буй системийн эмчилгээний аргууд

Озон эмчилгээний доор тайлбарлагдах арга замууд нь үр дүнтэй бөгөөд аюулгүй нь батлагдсан болно. Тухайлвал олон жилийн туршид хийгдсэн судалгаанууд болон эмнэлзүйн туршилтуудын үр дүнгийн талаарх 3000 гаруй нийтлэл баримтууд байдаг. Тэдгээрийг Озон Эмчилгээний Олон Улсын Шинжлэх Ухааны Холбооны номын сангаас онлайнаар үнэ төлбөргүй үзэж болно.⁹⁶

Дараах ном гарын авлагууд нь томоохон хувь нэмэр оруулсан болохыг дурдахад таатай байна. Эдгээрт Оросын Озон Эмчилгээний Холбооноос 2008 онд гаргасан “Handbook of Ozone Therapy (2008)⁹⁷”, Кубын үндэсний шинжлэх ухаан судалгааны төвийн шинжлэх ухааны нэгжээс 2008 онд гаргасан

“Ozone Basics Aspects and Clinical Applications (2008), Озоны үндсэн асуудлууд болон эмчилгээний аргууд²²” нэртэй Озон эмчилгээний удирдамж, Германы Анагаах Ухааны Нийгэмлэгээс 2009 онд урьдчилан сэргийлэх зорилгоор хэвлэн гаргасан “Эмнэлгийн озоныг ашиглах нь, The Guidelines for the Use of Medical Ozone (2009)⁹⁸” удирдамж, Доктор Велио Боччигийн ”Шинэ эм буюу A New medical drug(2010)⁵¹” нэртэй озоны ном, сүүлийн үеийн нийтлэлд тооцогдох Адриана Шварцын “Озон эмчилгээний эмнэлзүйн гарын авлага ном, The book Clinical Ozone Therapy Manual (2017)²⁴” болон 2018 оны FIO-гийн бага хуралд хэлэлцүүлсэн “Guidelines and Good Practice in Ozone Oxygen Therapy, Озон-хүчилтөрөгч эмчилгээний сайн туршлагауд болон удирдамжууд сэдэвт илтгэлүүдийг⁹⁹” дурдаж болно.

3.1.1 Их хэмжээний цус озонжуулах эмчилгээ ((МАН)

Их цус озонжуулалт (МАН) гэдэг нь өвчтөний цуснаас тодорхой хэмжээгээр авч эмнэлгийн зэрэглэлийн озоны холимогтой (O2-O3) холин нэн даруй буцаан дусал маягаар венийн судсаар хийх эмчилгээ юм.⁴⁴ Хэрэглэх цусны хэмжээ 50 мл-ээс 100 мл хооронд хэлбэлздэг. Гэсэн хэдий ч 200 мл-ээс их хэмжээний цус авах эсвэл өндөр настан биеийн байдал тогтворгүй байгаа өвчтнүүдэд болгоомтой хийхгүй бол гемодинамик өөрчлөлтөд орж болзошгүй. Биеийн жинд тохируулан цус авах нь тохиромжтой. Нийт эргэлдэж буй цусны (CBV) 15%-ыг алдахад гиповолеми/гемодинамик өөрчлөлтөд орохгүй. МАН эмчилгээний үед нийт эргэлдэж буй цусны 1.5%-2% -ыг авах нь тохиромжтой. 85 кг жинтэй хүнд $CBV = 65 \text{ мл/кг} * 85 \text{ кг} = 5525 \text{ мл}$ нийт цус үүний 2% нь 104.5мл цус авахаар байна.

Цус авах тохиромжтой хэмжээ нь: 1.2 мл/кг-аас 1.3 мл/кг хүртэл гэж тооцоолон нийт авах цусны хэмжээ 150 мл-ээс ихгүй байхад болно.

Жишээлбэл: 85 кг жинтэй хүн; $1.2 * 85 = 102 \text{ мл}$ цус авна. Эдгээр тун аюулгүй бөгөөд үр дүнтэй болох нь батлагдсан.¹⁰⁰ Тэд эсийн бодисын солилцоог идэвхжүүлж, дархлаа дэмжин хоргүйжүүлэх нөлөө үзүүлнэ. Озон эмчилгээ хийх арга болгонд хамгийн бага болон хамгийн их тун, түүнчлэн концентраци, эзлэхүүн гэсэн хэмжигдүүнүүд байдаг.⁴⁴

Цус юүлэх хэрэгслийн багц.

Европын Холбооны (EU) хуванцар цус юүлэх төхөөрөмж нь UNI EN ISO 15747:2005 стандартыг хангасан байх ёстой. О₃-д ашиглах бүх сав, төхөөрөмж нь озонд тэсвэртэй байх ёстой бөгөөд эдгээр бодисууд нь организмд хортой тул фталатыг ялгаруулдаггүй байх ёстой. Ийм учраас МАН эмчилгээний үед шил хэрэглэхийг илүүд үздэг. МАН эмчилгээг шил биш хуванцар сав болон гялгар уутанд хийж байгаа тохиолдолд эдгээр нь озонд тэсвэртэй байх ёстой бөгөөд EU эсвэл FDA (АНУ-ын Хүнс ба Эм) -ээс гаргасан цус цуглуулах гэрчилгээтэй байх ёстой. Озонжуулсан цус сэлбэх эмчилгээ хийх өөр арга одоогоор батлагдаагүй байгаа болно.

Системийн үйлчилгээ бүхий озоны концентрац нь 10 мкг/Нмл-ээс 40 мкг/Нмл хүртэл байх ба 70 мкг/Нмл-80 мкг/Нмл болон түүнээс дээш концентрац нь цус задрах эрсдлийг нэмж, 2, 3 DPG,

антиоксидант буурч, улмаар дархлааны эсийг идэвхжүүлэх чадваргүй болох тул ашиглахаас зайлсхийх хэрэгтэй.

Антикоагулянт. Хамгийн тохиромжтой нь /ACD-A/ буюу цитрат декстрозын уусмал А, USP (2.13% чөлөөт цитрат ион) эсвэл цитрат натрийн 3.8% -ийг 100 мл тутамд 10 мл-ийн харьцаагаар хэрэглэх нь зүйтэй. Цусыг озонжуулахад гепариныг хэрэглэхийг зөвлөдөггүй, учир нь энэ нь тромбоцитопени¹⁰¹ болон тромбоцитийн агрегац¹⁰² үүсгэнэ.

ACD-A-ийн аюулгүй бөгөөд үр дүнтэй хувь хэмжээ нь 100 мл цус тутамд 7 мл-10 мл хооронд хэлбэлздэг.

Эмчилгээний давтамж. Озон эмчилгээний курс болон тун нь өвчтөний ерөнхий байдал, нас, үндсэн өвчнөөс хамаарна. Ерөнхий заавраар бол, таван эмчилгээ тутамд озоны тунг нэмэгдүүлж, улмаар 15- 20 удаагаар курс эмчилгээ болгон хийдэг. Эмнэлзүйн үүднээс авч үзвэл таваас арав дахь эмчилгээнээс эмчилгээний үр дүн мэдрэгдэж эхлэх бөгөөд 12 эмчилгээний дараанаас антиоксидант систем бүрэн идэвхжсэн байдаг.

Шулуун гэдсээр хийх тохиолдолд эмчилгээг Даваагаас Баасан гараг хүртэл өдөр бүр эсвэл долоо хоногт гурван удаа хийдэг. Харин МАН, O₃SS-ийн хувьд долоо хоногт хоёроос гурван удаа хэрэглэж болно. Курс эмчилгээг 5-6 сар тутамд давтаж болно.

3.1.2 Бага цустай озонжуулах эмчилгээ ((MiAH)

Бага хэмжээний цус озонжуулах буюу аутогемотерапия (MiAH) нь урьдчилан озон хүчилтөрөгчийн холимогоос (10мкг/Нмл-40мкг/Нмл) 5мл-10мл соруулсан тариурт судаснаас (5мл-10мл) цус антикоагулянтгүйгээр авч түүнийгээ 30 секунд орчим сайн холиод өгзөгний булчинд ⁴⁵ хийн холимгийг аажим тарих арга юм. Энэ нь дархлааг өөрөөр нь сэргээх вакцин гэсэн үг.

Хийх заалт: Арьсны бүх төрлийн өвчнүүдийн үед хэрэглэх үндсэн заалттай. Тухайлбал, псориаз, дерматит, батга, харшил, арьсны идээт үрэвслүүдийн үед авто вакцин эмчилгээний журмаар мөн хавдар болон архаг сульдалтын үед туслах зорилгоор хийдэг.

Хийх арга: Урьдчилан озон хүчилтөрөгчийн холимогоос (5мл, авах цустайгаа ижил хэмжээний хийн холимог) 20 мл-ийн тариурт соруулж судаснаас (5мл-10мл) цус антикоагулянтгүйгээр авч түүнийгээ 30 секунд орчим сайн холиод өгзөгний булчинд ⁴⁵ хийн холимгийн хамт аажим тарина.

Курс эмчилгээ : долоо хоногт нэг удаа 5-10 удаа эмчилгээ хийнэ.

3.1.3 Озонжуулсан давсны уусмал (O₃SS)

Озонжуулсан давсны уусмал (O₃SS) нь Нижний Новгород (Ижил мөрний холбооны тойрогдахь Оросын озон эмчилгээний сургуулиас боловсруулсан Орос улсад өргөн тархсан эмчилгээний арга юм.¹⁰³ O₃SS нь Эмнэлзүйн өмнөх¹⁰⁴⁻¹⁰⁶ болон 92 гаруй эмнэлзүйн туршилт^{107,108} судалгаа (гол төлөв орос хэл дээр хэвлэгдсэн) болон 500 гаруй их сургуулийн диссертацийн судалгаа шинжилгээгээ хийгдэж

баталгаажуулагдсан байдаг. Энэ нь магадгүй Озоны эмчилгээний хамгийн өргөн цар хүрээтэй, шинжлэх ухааны үндэслэлтэй батлагдсан арга боловч энэ нь зөвхөн Орос улсад төдийгүй латин хэлээр хэрэглэгдэх, судалгаа шинжилгээ хийх нь ихэссэж Америк, АНУ, Испани улсуудад өргөн тархах болсон. Түүний үр ашиг нь 1992-2014 онд Орос улсад болсон найм дахь удаагийн практик эрдэм шинжилгээний бага хуралд өргөн мэдүүлсэн олон тооны эрдэм шинжилгээний судалгааны үр дүнгээр нотлогддог.¹¹⁰ Олон улсын мэдээллийн санд гарсан сүүлийн үеийн зарим судалгаанаас үзэхэд энэ аргыг клиникт хэрэглэх боломжтойг харуулсан. Тухайлвал Цочмог мухар олгойн үрэвсэл,¹¹¹Тархины гэмтэл,¹¹² Чихрийн шижингийн хөл,¹¹³ бөглөрөлт шарлалт,¹¹⁴ Бэлэг эрхтний мэдрэлийн цагаан судлын эмгэг,¹¹⁵ Ургийн өсөлт удаашрах⁵⁷, доод мөчдийн лимфовеноз дутагдал¹¹⁶ зэрэг болно.

Озоны химийн чиглэлээр ажилладаг дэлхийн томоохон мэргэжилтэн, профессор С.Разумовский тэргүүтэй судлаачдын баг усан орчинд озоны задралын процессыг судалсны дүнд озоны усан уусмал дахь озоны задралын байдлыг олж тогтоожээ. NaCl нь хүчилтөрөгчөөс өөр бүтээгдэхүүн үүсгэдэггүй бөгөөд ялангуяа гипохлорит, хлоратын мэдэгдэхүйц хэмжээ ажиглагдаагүй. Ийнхүү озонжуулсан изотоник уусмал нь эмнэлгийн хэрэглээнд ач холбогдолтой гэдэг нь батлагджээ.¹¹⁷

Нижний Новгородын Анагаах Ухааны Академийн Шинжлэх ухааны судалгааны төвд Оросын эрдэмтэд академич А.Королевын удирдлаган дор 1977 оны 10 дугаар сард озонжуулсан давсны уусмалын аргыг амжилттай боловсруулж, 1979 оны дөрөвдүгээр сард дэлхийд анх удаа төрөлхийн зүрхний эмгэгтэй өвчтөний титэм судасны системд кардиоплег (cardioplegic) озонжуулсан уусмалыг хэрэглэсэн. 1986 оны 11-р сард хиймэл митрал хавхлагыг байрлуулах үед анхны экстракорпораль озонжуулсан цусыг хийсэн.

Озонжуулсан давсны уусмалыг дөрвөн аргаар бэлтгэж болно

- **Эхний арга.** Гурван зүүний арга: Уусмалыг озоны хийгээр байнга ханасан байлгахын тулд тогтмол озонжуулж байх шаардлагатай.
- **Хоёр дахь арга.** Хоёр зүүний арга: Уусмалыг 10 минутын турш озонжуулан озоны концентраци буурахаас сэргийлэн маш яаралтай дулаар хийх шаардлагатай.
- **Гурав дахь арга.** Хоёр ба гурван зүү хэрэглэдэг аргуудын хослол юм. Энэ тохиолдолд 2 зүүний аргаар эхлээд давсны уусмалаа озонжуулаад судсаар хийх явцдаа бас тогтмол озонжуулах арга. Давсны уусмал дахь озоны агууламж тогтвортой байх шаардлагатай. Энэ аргад тусгай тоног төхөөрөмж шаарддаг.
- **Дөрөв дэх арга.** Европын Холбооны (СЕ) тамгатай, фталат агуулаагүй, озонжуулсан цус болон давсны уусмалд ашигладаг эмнэлгийн хэрэгслийн ангилалд багтсан хаалттай систем бүхий Dual Kit-ийг Испани улсад зохион бүтээж хэрэглээнд нэвтрүүлсэн.



Озоны санал болгож буй тун хэмжээ. Озонжуулсан давсны уусмал (O_3SS) нь өвчтөний жингийн дагуу тооцоолсон озоны маш бага концентрацитай хийгддэг.

Озоны бага тун: 1 мкг/кг.

Озоны дундаж тун: 2 мкг/кг.

Озоны өндөр тун: 5 мкг/кг.

O_3SS бэлтгэх озоны хийн агууламжийн тооцоолол:

Давсны уусмал руу хийсэн озоны хийн концентратын 25 % нь л уусмалд шингэж судас руу орно гэсэн үг. Тийм учраас үүнийг тооцон аппаратнаас авах тунг тохируулах хэрэгтэй болдог. Өөрөөр хэлбэл аппаратнаас гаргаж байгаа тунгаа 4-р үржүүлэн нэмж гаргаж байж хүнд орох тунгаа 100% болгоно гэсэн үг юм.

Тунгийн томьёо (Dose).

Нийт тун (μg) = уусмалд ууссан концентрац ($\mu g/mL$) · Давсны уусмалын эзлэхүүн (mL) Жишээ: Биеийн жин = 80 kg; Давсны уусмалын хэмжээ = 200 mL.

Озон бага тунгаар гэхэд.

Нэг удаад авах озоны тун = $1 \mu g/kg \cdot 80 kg = 80 \mu g$.

Давсны уусмалд ууссан концентрац нь = $80 \mu g/200 ml = 0.4 \mu g/NmL$.

Тэгэхээр аппарат дээр сонговол зохих концентрац нь = давсны уусмалд уусвал зохих хэмжээгээ 4-р үржүүлэх буюу = $1.6/ \mu g/NmL$.

Дунд зэргийн тун. 2 $\mu g/kg$.

Нэг удаад хийх хэмжээ = $2 \mu g/kg \cdot 80 kg = 160 \mu g$.

Давсны уусмалд ууссан байвал зохих хэмжээ = $160 \mu g/200 mL = 0.8 \mu g/NmL$.

Аппарат дээр сонгох хэмжээ нь = Давсны уусмалд ууссан байвал зохих концентрац* 4 = $3.2 \mu g/NmL$.

Озоны өндөр тун. 5 $\mu g/kg$.

Нэг удаад хийх нийт тун = $5 \mu g/kg \cdot 80 kg = 400 \mu g$.

Давсны уусмалд ууссан байвал зохих озон. = $400 \mu g \cdot 200 ml = 2 \mu g/NmL$.

Аппарат дээр сонгох хэмжээ = Давсны уусмалд уусвал зохих озоны хэмжээг * 4 = $8 \mu g/NmL$.

Озонжуулсан давсны уусмал дахь озоны агууламжийн дээд хязгаар нь 2 мкг/Нмл ($\mu g/NmL$); Энэ хязгаараас хэтрэх нь аюултай бөгөөд флебит үүсгэдэг. Өндөр тун шаардлагатай онцгой тохиолдлууд тухайлвал хүнд хэлбэрийн сепсис, хүнд хэлбэрийн вирусын халдварууд, Ийм тохиолдолд концентрацийг 5 мкг/Нмл хүртэл 8 мкг/Нмл хүртэл нэмэгдүүлж болно.

Анхааруулга: Нэг удаагийн эмчилгээний хувьд давсны уусмалын хэмжээ (200-400) мл байна. Нэг курс эмчилгээний тоо 6-аас 10 удаа байна. Эмчилгээ нь өдөр бүр эсвэл нэг өдөр алгасаад хийгдэнэ.

Нам тунгаар (0.4 мкг/Нмл, $\mu\text{g}/\text{NmL}$) дархлаа идэвхжүүлэх, зүрх судасны өвчнийг эмчлэхэд хэрэглэдэг. Мөн эх барихын асуудлуудын хувьд жирэмсний эхний гурван сарын хордлого, гурав

дахь гурван сард ургийн гипокси үүсэхээс сэргийлэхээр хэрэглэдэг. Хавдраас урьдчилан сэргийлэх болон дэмжих эмчилгээнд өргөн хэрэглэгддэг.

Дундаж тунгаар (0.8 мкг/Нмл, $\mu\text{g}/\text{NmL}$) эндо-токсемийн үеийн хордлого тайлах болон янз бүрийн шалтгаант архаг үрэвсэлт өвчний үед хоргүйжүүлэхэд хэрэглэнэ.

Өндөр тунгаар (2 мкг/Нмл, $\mu\text{g}/\text{NmL}$) халдварт (бактерийн ба вирус) өвчний эмчилгээнд, түүнчлэн арьс, түлэгдэлтийн өвчний эмчилгээнд хэрэглэдэг. Мөн аутоиммун өвчний үед дархлаа дарангуйлах тун шаардлагатай үед хэрэглэнэ.

3.1.4 Цусыг биеийн гадна озонжуулах EBOO)

Энэ аргыг Итали, Орос, Украин, Малайз, Латин Америкийн зарим орнуудад ихэвчлэн захын артерийн хүнд өвчин, титэм судасны өвчин, хүнд хэлбэрийн дислипидеми, Маделунгийн өвчин, судасны гаралтай дүлийрэл, үхжилт фасцит, септицеми, антибиотикт тэсвэртэй халдвар, ишемийн харвалт, зүрхний архаг дутагдал, вируст гепатит “С” зэрэгт хэрэглэдэг. EBOO арга нь МАН-ийн дэвшилтэт хувилбар юм. EBOO нь гемодиализтай төстэй бөгөөд их хэмжээний цусыг (4 л/ц) бага тунгаар ($<1 \mu\text{g}/\text{mL}$) озонжуулах нь эмчилгээний үр нөлөөг нэмэгдүүлдэг.

EBOO процедур нь өвчтөний венийн нэг судаснаас хийн солилцоо хийх төхөөрөмжрүү (GED) явуулаад дараа нь тэр төхөөрөмжөөс өөр нэг хураагуур судас руу хийх арга. Дээд болон доод хураагуур судаснууд байж болно.

Энэ эмчилгээг хийх хоёр гол арга байдаг EBOO.⁴⁸

EBOO-гийн *Эхний аргачлал* нь озонд тэсвэртэй, полипропилен микро шүүр болон гуурсууд (гадна диаметр нь 200 мкм, зузаан нь 50мкм, хальсны гадаргуу нь 0,22м) бүхий хийн солилцоо хийх төхөөрөмжид (GED) тулгуурласан. Хүчилтөрөгч-озоны хольцын концентраци ойролцоогоор 99% ба 1% байна. Уг эмчилгээний үед өвчтөний цусыг хөндий суваг руу шилжүүлж, озон-хүчилтөрөгчийн хольц нь сувгийг гаднаас нь хүрээлдэг.

Хоёрдахь арга нь эргүүлэг ба хальс GED (хэвтээ эргэдэг шилэн сав, озонд тэсвэртэй полипропиленээр хийсэн гурван товч үл хөдлөх бөглөө зэргээс бүрдэнэ) ашиглахад оршино. Хэрэв эмчилгээ нь нэг цагаас илүү үргэлжилэх тохиолдолд заавал гепарины нэмэлт тунг (1 мл, 5000 IU) хийх хэрэгтэй. Уг эмчилгээ нь GED-ээс давсны уусмалыг ашиглан цусаа шилжүүлж, венийн судаснаас гуурсуудаа авч дуусгана.

Анхааруулга: Гемодиализ хийхэд ашигладаг орчин үеийн диализаторууд нь полисульфон, купрофан болон бусад нь озонд тэсвэртэй бус материалаар хийгдсэн байдаг. EBOO-д ийм төхөөрөмжийг ашиглах нь эрсдэлтэй байх болно.^{93,119-121}

3.1.5 Шулуун гэдсээр хийх (RI)

Озоныг шулуун гэдсээр нэвтгүүлэх нь системийн аргын нэг юм.⁴⁷ Энэ хий нь гэдэсний салст бүрхүүлээр хурдан уусдаг бөгөөд антиоксидант үйлчилгээтэй салст уураг болон бусад шүүрлийн бүтээгдэхүүнүүд озонтой шууд урвалд орж реактив хүчилтөрөгч (ROS) болон липидийн хэт исэлдэлтийн бүтээгдэхүүн үүсгэдэг. Эдгээр нэгдлүүд нь булчингийн салст бүрхэвчийг нэвтлэн венийн болон тунгалгийн хялгасан судасны эргэлтэнд ордог.¹²² Энэхүү инвазив бус аргыг хүүхэд болон өндөр настан мөн МАН эмчилгээ хийхэд захын венийн судас нь боломжгүй өвчтөнүүдэд хэрэглэхэд эрсдэлгүй. Ерөнхийдөө энэ нь МАН шиг схемчилсэн тун авах боломжтой бөгөөд өвдөлтгүй тааламжтай аргад тооцогддог.

Архаг өвчнүүдийн хувьд эмнэлгийн озоны тохирсон тун нь исэлдэлтийн стресс тэвчилийг түр зуур үүсгэдэг учир өвчтөнүүдэд давталттай (өдөр бүр нийт 20 удаа) курсээр хийх хэрэгтэй болдог. Дараагийн курс бүрт тунг нэмэгдүүлэн эхний жилд 3-4 сарын завсарлагатайгаар давтан хийдэг. Хэрэв завсарлага нь 6 сараас хэтэрвэл дахин эхний тунгаараа хийдэг. Бага, дунд, дундын дээд тунгуудын хувьд хамгийн үр дүнтэй бөгөөд гурван сарын давтамжтай хоёр курс эмчилгээ хийсны дараа л өндөр тун руу орох боломжтой гэж үздэг.

Концентрацын хувьд (10–5) $\mu\text{g}/\text{NmL}$. Хэмжээний хувьд (100–200) mL.

40 $\mu\text{g}/\text{NmL}$ -ээс дээш тун нь энтероцитийг гэмтээх эрсдэлтэй.

3.1.6 Үтрээгээр озон эмчилгээ хийх

Хялгасан судасны урсгалын хурд ихтэй мөн үтрээ нь өргөн, цэвэр, чийглэг, сайн судасжилттай эрхтэн гэдэг утгаараа үтрээний озон эмчилгээ нь системийн арга бөгөөд МАН болон RiO_3 -аас ч илүү үр дүнтэй арга юм.¹²³

Озоны концентрацийг (10-30) $\mu\text{kg}/\text{NmL}$ -ээр тохируулан (1-2) литрийг 10 минутын турш 0.1 л/мин-аас 0.2 л/мин хүртэл хурдтай урсгалаар тасралтгүй шахаж хийнэ. Урьдчилаад үтрээг озонжуулсан усаар угаасан байх хэрэгтэй. Энэхүү аргачлалын хувьд үтрээний салст бүрхэвчийн атираа руу хийн холимогын жигд, зөв, аюулгүй тархалтыг бий болгохын тулд илүүдэл озон шингээгч болон үтрээний тусгай төхөөрөмжийг ашиглах хэрэгтэй болдог.^{46,124} Салст бүрхэвчийг озоны хуурайшуулах нөлөөнөөс хамгаалахын тулд эмчилгээг хийсний дараа тусгай тос хэрэглэх нь зүйтэй.

3.2 Хэсэг газрын үйлчилгээ бүхий аргууд

3.2.1 Булчинд, багана нуруу хооронд болон үений дотор тарих

Дэлгэрэнгүйг: ISCO3 (2014) Ozone in Non-Rheumatic Locomotor System Pathologies⁴⁰

3.2.2 *Багана нурууны булчинд тарих*

Үндсэн багана нурууны булчинд нэвчүүлэх тарилгыг хийхдээ нурууны гол шугамнаас хажуу тийш

1.5см-ийн зайд нуруу болон хүзүүний нугалмын сэртэнгийн дээд хэсгээр 5 мл озоныг (10-20)мкг/ NmL-ээр (0.8 x 40)мм зүү ашиглан гүйцэтгэнэ.^{41,125-127}

Харин бүсэлхий нурууны нэвчүүлэх тарилгыг нугалмын сэртэнгээс 2.0см-ийн зайд дээрхтэй ижил концентрацаар 10 мл-ээр хийдэг. Ивэрхийтэй тохиолдолд зүү хатгах газрыг сонгохдоо ивэрхийнээс хажуу болон хоёр талд мөн дээр доор 2 см орчимд авна. Өвчтөний бие бялдарын байдлыг харгалзан үзэж эмчилгээ хийх талбараа бодолцож 2-4 см-ийн гүнд хатгалт хийдэг. (туранхай өвчтөнд голын шугамд ойр өнгөц, таргалалттай өвчтөнүүдэд бүсэлхий талруугаа гүн гэх мэт).

Хэсэг газрын мэдээ алдуулалтанд 1мл прокайн эсвэл 1мл лидокайныг сонгож болно. Энэ нь озоны өвдөлтийг бууруулдаг талтай. Мэдээ алдуулалт хийсэн тохиолдолд исэлдэлтээс сэргийлэн озоны хэмжээг хэтрүүлэхээс сэрэмжлэх хэрэгтэй. Өвчтөнд халуун оргих мэдрэмж төрнө.

Туршлагаас үзэхэд эхний 2 долоо хоногийн хувьд долоо хоногт 2 удаа тарина. Өвдөлт зовуурь намдмагц долоо хоногт нэг удаагаар 4-6 долоо хоног эмчилгээг үргэлжлүүлнэ. Харин дараа нь 15 хоног тутамд нэг удаа хийн курс эмчилгээ болох 20-ыгоо гүйцээнэ. Өвдөлт зовуурь эрт намдвал курсын тоог багасгаж болно. Өөр өөр давтамжийг хэрэглэж байсан санамсаргүй тохиолдол хяналттай судалгаануудад долоо хоногт 5 удаа гурван долоо хоногийн турш хийсэн нь үр дүнтэй гэж гарсан ч байдаг.

Энэ үйлдлийг (0.4 x 40) mm-ээс 30G (0.3 mm) x 1½ (40 mm) хэмжээс бүхий зүү ашиглана гүйцэтгэнэ. Зарим тохиолдолд бүр урт зүү ч шаардлагатай болдог.

Ер нь эмчилгээний өмнө ууц нуруу болон сүүж ахар сүүлний үе булчингуудын байдал, үрэвсэл болон өвдөлтийн голомт цэгүүдийг эмч шалган тодруулах нь чухал.

Хэрвээ өвчтөнүүд дискийн артрозтой байвал багана нуруу орчмын энэ тарилганд намддахгүй байж болох бөгөөд хэрэв тийм бол (10-20) µg/ NmL -концентрацаар (5-20) мл-ийн хэмжээгээр (50-400) мг тунг хийдэг.¹²⁸

3.2.3 *Ивэрхий*

Багана нуруунд тарилгыг гүн хийх

Энэ тарилгыг 0,4мм эсвэл 0,5мм*90 мм урт нугасны зүүгээр давхаргуудын дээгүүр нугасны нүхний ойролцоо эсвэл үений уугны эргэн тойронд хийх хэрэгтэй. Хүзүү нурууны ивэрхийн үед: концентрац (10-20) µg/NmL, хэмжээ (3-5) мл, нурууны ивэрхийд бол концентрац (10-20) µg/NmL, хийх хэмжээ нь (7-10) мл байдаг.¹²⁹

3.2.4 Диск дотор тарилт

Ер нь бол рентген флюроскоп болон компьютер томографийн/СТ/-ын хяналтанд гүйцэтгэх шаардлагатай ганц ажилбарт тооцогддог.¹³⁰

Өвчтөнд тайвшруулалт, өвдөлт намдаалт (ерөнхий мэдээ алдуулалт биш) хийх ба эмчилгээ хийсэн тэр өдөр антибиотик эмчилгээг урьдчилэн сэргийлэх зорилгоор авдаг. Зарим тохиолдолд диск дотор тарилтыг 2-4 долоо хоногийн дотор давтан хийж болдог.

Бүсэлхий нурууны диск гулссан тохиолдолд 25-35 $\mu\text{g}/\text{NmL}$ концентрацаар 5-10 мл хэмжээтэй хүчилтөрөгч-озоны холимог хийдэг.^{131,132} Амьтанд хийгдсэн судалгаанууд дээр 50 mkg/NmL ба түүнээс дээш концентрацийг хэрэглэхгүй байхыг зөвлөдөг учир нь дискны эвдрэл, гэмтэл үүсч байсан тул эмчилгээнд 40 mkg/NmL -ээс дээш тунг хэрэглэхгүй байвал зохино.¹³³ Ашигладаг зүүний хувьд Chiba 25G x 3 1/2 (0.5 x 90) (хэвийн) эсвэл 22G (0.7 x 203)мм (илүү жинтэй өвчтөнүүд) хэмжээг сонгодог.

Хүзүүний диск гулсалтын хувьд (2-3)мл хүчилтөрөгч озоны холимогыг (25-35) mkg/NmL концентрацаар хийдэг.^{131,132} Ашигладаг зүү нь бол Chiba 25G X 11/2” (0.5 X 40 мм) юм.

Озоноор дисколиз хийхэд зөвхөн нэг эмчилгээний дараа үр дүн гарах боловч тодорхой дэд бүтэц (радиологийн хяналтанд), мэдээ алдуулагч эмч, техникийг гүйцэтгэх туршлагатай боловсон хүчин шаарддаг. Эс бөгөөс нурууны хажуугийн булчингаар нэвчүүлэх тарилгын арга нь харьцангуй олон хийх шаардлагатай боловч хамгийн эрсдэлгүй бөгөөд үр дүн нь ялгаагүй сайн байдаг.

3.2.5 Ууц нуруунд

Энэ тарилтыг хатуу хальсны доорхи зайд долоо хоногт 2 удаа ЭХО аппараты хяналтан дор тарина. Хүчилтөрөгч озоны холимог хамгийн ихдээ гэхэд л 10-20 мл хэмжээтэй хийх ба концентрац нь (10-20) $\mu\text{g}/\text{NmL}$ байна. Transluminal peridural арга буюу sacral hiatus замаар дамжих арга нь дискэн доторх тарилгын аргатай харьцуулахад шууд бус арга боловч озоноор дискний ивэрхийг эмчлэх өөр нэг хувилбар нь юм. Учир нь:

- Энэ аргын хувьд өвчтөн болон эмч аль аль нь туяанд өртөх эрсдэлтэй.
- Озоны үйлчилгээ нь диск болон үений түвшинд хатуу хальс дорх хийн хуримтлалаас гэмтсэн ёзоор болон дискийн аль алинд үйлчилдэг.
- Энэ нь материал болон хэрэгсэл бага шаарддаг атлаа үр дүнтэй арга юм.
- Багана нурууны хажуугийн булчинд хийх аргатай харьцуулахад энэ шууд бус арга цөөхөн хийгддэг атлаа олон дискийн ивэрхийтэй үед илүү үр дүнтэй байдаг.
- Эмчилгээний үр дүн 70%-иас дээш байдаг.
- Энэ аргын хувьд эдгэрэлт түргэн байдаг.
- Энэ арга нь олон төрлийн өвчин хавсарсан өвчтнүүдэд хийхэд тохиромжтой.

Ямар ч тохиолдолд халдваргүйжүүлэлт, багажны ариутгал болон зөвшөөрлийн бичиг заавал хийсэн байх шаардлагатай.

3.2.6 *Нугаламын хөндийд тарих*

Концентрац нь: (10-20) $\mu\text{g}/\text{Нмл}$.

Хүзүүний нугалмуудын дотор хөндийд хийх арга нь рентгений хяналтан дор 5 мл-ийг 25 G*11/2` `(0.5*40 мм) зүү ашиглан хийдэг.^{134,135}

Нурууны нугалмуудын дотор хөндийд тарихдаа: (7-10)мл болон Chiba 25G x 3 1/2 (0.5 x 90) (хэвийн) эсвэл 22G (0.7 x 203)mm (илүүдэл жинтэй хүмүүст) -ийн нурууны зүүг ашигладаг.¹³⁵⁻¹³⁸

3.2.7 *Үений дотор хийх эмчилгээ*

Концентрац: (2-10-20) $\mu\text{g}/\text{Нмл}$,

Хийн хэмжээ нь үений хэмжээнээс хамааран харилцан адилгүй байдаг: тухайлбал хуруунд 1-2мл бусад үенд 5-20мл.¹³⁹⁻¹⁴¹

3.2.8 *Бээлийн техник (арьсан дор хий шахах техник)*

Гарын арьсан дор нэвчүүлэх тарилга хийх (10-40)мл хүчилтөрөгч озоны холимгийг (5-20) $\mu\text{g}/\text{Нмл}$ концентрацаар 30G (0.3mm) зүү ашиглан хийдэг. Энэ тарилт нь мэдрэлийн гаралтай өвдөлт болон яс ургалтанд үр дүнтэй.⁴²

3.2.9 *Хуванцар уут ашиглах арга*

Озонтой уут ашиглах нь хэсэг газрын эмчилгээний арга. Хүчилтөрөгч болон озоны холимогыг озонд тэсвэртэй хуванцар дүүргээд шархны эргэн тойронд орчин үүсгэн биеийн эд эсэд озоны хийг шүргэлцүүлэх зорилогтой.

Концентрацийн хувьд (80,70, 60, 40, 30, 20) $\mu\text{g}/\text{NmL}$ -ыг (20, 10, 5) минутаар шархны үе шат болон байдалтай харгалзан сонгоно. Харин (60-80) $\mu\text{g}/\text{Нмл}$ -ийн концентрацийг зөвхөн идээт үжилт халдварын үед маш богино ер нь 5 минутаас хэтрэхгүй хугацаанд ашигладаг. Шархны эдгэрэлт ажиглагдангуут өөрөөр хэлбэл эрүүл төлжилт харагдаад эхэлвэл эмчилгээний давтамж болон концентрацийг бууруулах замаар эдгэрэлтийг дэмждэг.¹⁴²⁻¹⁴⁴

Анхааруулга: Эмчилгээ хийх талбайг урьчилан чийглэн уутан дотрох хийг вакуумжуулан соруулж авсны дараа хүчилтөрөгч/озоны холимогыг хийнэ. Ажилбарын төгсгөлд уутаа салгахаас өмнө түүнд үлдсэн озоноо соруулж авсан байх ёстой.

3.2.10 *Арьсан дор хийх*

Энэ арга нь гоо сайхны зорилгоор батга¹⁴⁵, целлулит зэрэгт хийдэг. Целлюлитэд хийхдээ нэг удаад 200 мл-ээс их хийж болохгүй ба 5-10 см-ийн зайтайгаар цэг тус бүрт 2-3 мл хийнэ.

Концентрац нь 15 мкг/NmL аас 20 мкг/NmL, байх ба зүү нь 27G (0.3 mm) байна. Долоо хоногт 2 удаагаар нийт 15-20 удаа хийж курс эмчилгээ болно.^{145,146}

Энэхүү эмчилгээ нь RI, МАН болон O₃SS эмчилгээнүүдтэй хавсарч долоо хоногт хоёр удаа хийгдвэл илүү үр дүнтэй.

3.2.11 *Озон бумбаны арга*

Эмчилгээг 15 мкг/Нмл-ээс 60 мкг/ NmL хүртэлх концентрацит бүхий хийн холимгоор 5-20 минутын турш хийнэ. Бумба дотор байгаа агаарыг вакжуулан соруулах шаардлагатай. Вакуум нь цусны урсгалыг нэмэгдүүлж, озоны үйлчилгээг нэмэгдүүлнэ.

3.2.12 *Хөндийд нэвчүүлэх арга*

Энэ аргыг хэрэглэхдээ юуны түрүүн анхаарах зүйл бол энэ хөндий амьсгалын замтай холбогдож байгаа эсэхийг тодруулна. Арьс, мэс заслын дөрөөх хөндий болон хошногоны эргэн тойрон зэрэгт битүү хөндий, бөглөрөл эсвэл уйланхайт хий үүсч тухайн хэсэгт даралт өгч өвдөлт үүсгэж болзошгүйг бодолцох хэрэгтэй. Хийг хийхийн өмнө озонжуулсан усаар хөндийг угаана. Тэгээд хүчилтөрөгч озоны холимогийг (10-80) мкг/Нмл концентрацаар 5 минутаас 20 минутын хугацаанд озонжуулна.¹⁴⁷

3.2.13 *Нүдний эмчилгээ*

Нүдний эмгэгийн үед (кератит, эвэрлэгийн шархлаа, конъюктивит, нүдний түлэгдэл)¹⁴⁸ нүдний хэлбэрт тохирсон тусгай шилэн бүрхүүл хэрэглэнэ. Озоныг хий эсвэл озонжуулсан тос хэлбэрээр түрхэхэд хорсох зовиур өгөхөөс болгоомжилж эмчилгээний өмнө мэдээ алдуулагч нүдний дусаалга хэрэглэхийг зөвлөдөг. Озоны концентрац (20-30) мкг/Нмл-ээр сонгож 5 минутын турш хийдэг бөгөөд түүнийгээ долоо хоногт хоёроос гурван удаа хийнэ.

Нүдний зовхины доорхи тарилга хийхийн өмнө нүдний аяганы доорх уутанцар тус бүрт 1-2 мл мэдээ алдуулах тарилгыг хийнэ. Озоны тун нь 10-35 мкг/Нмл концентрацитай (1-2) мл байна.

Озонжуулсан тос (200-400) IP: Озонжуулсан тос нь нян, вирус устгах шинж чанартай байдаг тул өдөрт 4-5 удаа нүдний дусаалга хэлбэрээр түрхэх нь зүйтэй. Гэхдээ нүдэнд озоны хий орохтой адил хорсох мэдрэмж үүсгэхгүйн тулд урьдчилаад хэсэг газрын мэдээ алдуулалтыг ашигладаг.^{24,149}

Озонжуулсан уусмалыг (10 мкг/Нмл) концентрацитайгаар нүдний хагалгааны өмнө угааж халдваргүйжүүлэхэд ашиглаж болно.¹⁵⁰

3.2.14 Давсаг шээс ялгаруулах замаар нэвчүүлэх арга

Давсаг шээс ялгаруулах замаар хийг шууд хэрэглэхгүй, харин озонжуулсан нэрмэл усаар угаахыг зөвлөж байна. Давсагны салст бүрхэвч нь ялангуяа завсрын эдийн циститын үед озоны исэлдэлтийн шинж чанарт хэт мэдрэмтгий байдаг.

20 $\mu\text{g}/\text{NmL}$ -ийн концентрацтай 500 мл нэрмэл усаар 10 минутын турш тасралтгүй 200мл/мин урсгалын хурдтай урсган озонжуулна.¹⁵¹⁻¹⁵⁵ Үйлдлийн төгсгөлд озонжуулсан уусмалаасаа 50 мл-ийг давсаганд үлдээнэ.

3.2.15 Түрүү булчирхайд

Түрүү булчирхайн цочмог болон архаг нянгийн үрэвслийн үед эмчилгээг дэлбэн бүрийн захын хэсэгт (peripheral area of each lobule) 20 мкг/Нмл концентрацтай 5 мл Озон хүчилтөрөгчийн холимгыг 27G x 2 хэмжээ бүхий зүүгээр хийдэг. Долоо хоногт нэг удаагаар нийтдээ 10 долоо хоног эмчилгээ хийж нэг курс болно.²⁴ Түрүү булчирхайн хоргүй гиперплазид 40 мл озон хүчилтөрөгчийн холимогыг 30 мкг/Нмл концентрацаар (дэлбэн бүрт 20 мл)-ээр тарина.^{155,156}

3.2.16 Чихээр хийх

Чихний сувгын эмчилгээний хувьд хэнгэргэн хальс бүрэн эсэхийг нь сайн шалгана. Озон нь хуурайшуулах шинж чанартай тул эмчилгээний өмнө чихний суваг болон чихний хэнгэргэн хальсыг чийгшүүлэхийг зөвлөж байна.

Озоныг чихэнд хийхийн тулд тариур эсвэл озоны үлдэгдлийг зайлуулагч тусгай толгойтай төхөөрөмж бүхий силикон чагнуур ашиглаж болно, эсвэл тариурыг угсрахын тулд Кунар-ийн "Y" болон эм буюу Luer lock холбогчоор холбосон силикон хоолой маягын чагнуураар чихэнд үлээлгэж болно. Мөн тодорхой концентрац бүхий озоноор дүүрсэн тариур ашиглаж болно. Үүнийг гараар, аажмаар хийх бөгөөд ингэснээр озоныг чихний суваг болон чихний мембран шингээж авах боломжтой болно. Хэрэв озоны урсгал бага байвал эмчилгээг илүү удаан хийх хэрэгтэй. Энэ хэрэгсэл нь озоны генераторт шууд холбогдох шаардлагагүй болно.

Концентраци: (10-25) мкг/Нмл; Хийх хугацаа: 5 мин.¹⁵⁷⁻¹⁵⁹

Заалт: Дунд чихний урэвсэл чихний сувгийн дерматит, синусит, толгой хүзүүний цусны эргэлтийн эмгэг.

3.2.17 Гүйлсэн булчирхайд нэвчүүлэх арга

Хоёр гүйлсэн булчирхайн өмнө болон арын хүнхэрхийд (10-20) мкг/Нмл концентрацтай 2 мл-ээс 3 мл озоны агууламжтайгаар хоёроос гурван цэгт хийдэг. Ер нь бол 4-5 удаа хийх хэрэгтэй болдог.

Хамрын хөндийн полипийн үед 50 мкг/Нмл концентрацитай 2мл эзэлхүүнтэй хийг полип эдэд шууд нэвчүүлнэ.¹⁶⁰ Амьсгалын замаар¹⁶¹ авах бол зөвхөн озонжуулсан тосны гидрозолийн төлөвт 5 мкм хэмжээтэй (дэгдэмхий органик нэгдлүүд) хэсгүүдийг хэт авиан генератор ашиглан хийнэ. Озоныг хэзээ ч үнэрлэж болохгүй.

3.2.18 Биологийн идэвхит болон зүүний цэгээр озоны бичил тунг тарих

Биологийн идэвхит цэгүүдээр тарилга хийхдээ ихэвчлэн булчингийн давхаргад 3-5) мл-ийн хэмжээтэй (6-9) мкг/Нмл концентрацаар хийдэг бөгөөд цөөн тохиолдолд анатомын байршлаас хамааран гүнд хийж болно.

Зүү эмчилгээний цэгүүдийн дагуу арьсан дотор (6-9) мкг/Нмл-ээс бага концентрацитай O3/O2-ийн хийн холимогийг (0.1-0.3) мл ба 1 мл хүртэл (хамгийн их) хэмжээгээр тарина.^{50,162}

3.2.19 Ус, тосон уусмал болон тосыг озонжуулан хэсэг газар хэрэглэх

Усанд ууссан озон болон озонжуулсан тосыг шарх, бохирдол бүхий гэмтэл, архаг эдгэрэхгүй байгаа шарх, хэвтрийн шарх, түлэгдэлт, хомхой, псориаз, мөөгөнцрийн халдвар, шавьжны хатгалт, шүдний халдвар зэрэгт шархны эдгэрэлт эдийн нөхөн төлжилт эсвэл халдварын эсрэг зэрэг ямар зорилгоор хэрэглэх гэж байгаагаас мөн ямар эдэд хаана хэрэглэж байгаагаас хамааран концентрацийг бага дунд их болгон тохируулж гадуур хэрэглэнэ Хүснэгт 3.¹⁶³⁻¹⁶⁶

Озонжуулсан уусмалыг бэлтгэхдээ $\frac{3}{4}$ орчим нэрмэл усаар дүүргэсэн шилэн цилиндрийг ашиглан хийн хольцыг ханасан байдалд хүргэхийн тулд дор хаяж (5-10) минутын турш тасралтгүй озонжуулах шаардлагатай. Ашиглагдаагүй үлдсэн Озон нь силикон гуурсаар дамжин саармагжуулагч руу орж хүчилтөрөгч болж хувирна (Хүснэгт 3А).

Озонжуулсан ургамлын тосны физик-химийн шинж чанарыг судлах нь тэдгээрийн шинж чанарыг ялган тодорхойлох нь чухал. Озонжуулсан тосны чанарыг тодорхойлохын тулд хэт исэл¹⁶⁷, хүчиллэг чанар¹⁶⁷, иодын хэмжээ,¹⁶⁸ харьцангуй нягт, зуурамтгай чанарыг тодорхойлох шинжилгээний аргыг ихэвчлэн хийдэг.

Хэт ислийн утга нь 1000 г дээжинд агуулагдах идэвхтэй хүчилтөрөгчтэй тэнцэх мл-ээр илэрхийлсэн хэт ислийн хэмжээг илэрхийлнэ (mEqO₂ / кг). Энэ индексийг тунгийн шалгуурт хэрэглэнэ (Хүснэгт 3 В).¹⁶⁹

Өндөр хүчдэлийн хоолойд тосны уурын тархалтаас зайлсхийх боломжгүй тул тосыг озонжуулах ажлыг эмнэлгийн генератороор хэзээ ч хийж болохгүй. Учир нь хэд хэдэн хорт бодис үүсэх болон тэсрэх аюултай. Хэт ислийг үнэлэхэд санал болгож буй арга бол Европын фармакопейд Занарди-гийн оруулсан хувилбараар(2008)¹⁷⁰ ISCO3¹⁶⁹-аар стандартчилагдсан. Нэмж дурдахад саяхан ISCO3 аас хүчиллэг¹⁶⁷ болон иодын үзүүлэлт¹⁶⁸ зэргийн бусад чанарын хяналтын шинжилгээг стандартчилсан.

3.2.20 Саун буюу биеийн бараг бүх гадаргууг озонд шүргэлцүүлэх

Озоны саун нь (гипертерми) халуун уур (40-42)°C-ийг бага концентраци бүхий (5 мкг/Нмл) O₂/O₃-тай хослуулдаг. Озонд байх хугацаа зөвхөн 10 минут бөгөөд дараа нь бас 10 минут ууранд сууна. Биеийн бараг бүх хэсэг бага (5- 10 μg/Нмл) концентрацтай холимогт байх бол дунджаар 20 минут орчим байдаг. Энэ нь хордлого тайлах, гоо сайханы эмчилгээ, стресс тайлах, булчингийн чангарал, цусны эргэлтийг сайжруулах, биеийн ерөнхий халдварын өвчин, псориаз зэрэгт сайн гэж үздэг. Эдгээр аргуудыг ашиглан клиник туршилт хийх шаардлагатай байна.

Хүснэгт 3. Ус болон озонжуулсан тосон дахь озоны тунгийн хэмжээ.

Хүснэгт 3 А. Ус озонжуулалтын ерөнхий шаардлага.

Нэрмэл ус озонжуулалт					
Арга	Онцлогууд	Түвшин			Тэмдэглэл
		Өндөр	Дунд	Нам	
1. Хэсэг газрын эмчилгээнд бол өндөр концентрацтай O ₃ -ийг ашиглана. 2. Уухад бол нам концентрацыг хэрэглэнэ.	O ₃ Cg (мкг/Нмл)	80	60-40	20-10	Усан дахь озоны эцсийн концентраци 20°C-ийн (нэрмэл ус) нь ихэвчлэн 1/4 (25%) - тай O ₃ концентрацтай тэнцдэг. 1. Ойролцоогоор озонжуулах хугацаа нь 3л/цаг урсгалтай үед (5-10) мин байна. Эдгээр параметрууд нь O ₃ урсгал болон озонжуулж байгаа төхөөрөмжийн төрлөөс хамааран хувьсах боломжтой.
	V.H ₂ O (мл)	Усны хэмжээ бол эмчлэх талбараас хамаарна (доорх практик жишээг үзнэ үү).			
	O ₃ -C _w мкг/Нмл	20	15-10	5-2,5	
Озонтой ус хэрэглээний жишээнүүд 1) Гадуур хэрэглээ 2) Уухаар бэлдэх	O ₃ Cg(мкг/Нмл)	80			
	Нэрмэл усны эзлэхүүн (мл)	500			
	Озонжуулах хугацаа (минут)	10			
	Төгсгөлд Озоны концентрац(мкг/мл)	20			
	Хэрэглээний жишээ: хэвтрийн холголт, ил шарх				
	Озоны хийн концентрац (мкг/Нмл)	10			
	Нэрмэл усны хэмжээ (H ₂ O мл)	250			
	Озонжуулах хугацаа (минутаар)	5			
Усан дахь озон төгсгөлдөө (мкг/Нмл)	2,5				
Хэрэглээний жишээ: Ходоодны шарх					

Анхааруулга: Усан дахь озоныг силикон эсвэл Teflon® таглаатай нягт хаалттай шилэн саванд, хөргөгчинд хадгалах ёстой. Хэрэв 5°C-т байлгавал озоны концентраци 110 цагийн дотор хоёр дахин буурдаг бол 20°C-д озоны хагас задралын хугацаа ердөө 9 цаг болно.⁵¹ Товчлол. Cg: озоны хийн агууламж; C_w: усан дахь озоны агууламж; V: эзлэхүүн.

Хүснэгт 3 В. Озонжуулсан тосны техникийн үзүүлэлтүүд.

Озонжуулсан Тоснууд					
Арга	Томьёолол	Түвшин			Тэмдэглэл
		Өндөр	Дунд	Бага	
Озонжуулсан тос	PV (mEqO ₂ /кг)	800-1200	600-400	400-200	Энэ аргад зөвлөдөг хэт ислийн утгыг тодорхойлоход санал болгож буй арга нь Европын фармакопейны дагуу буюу Занарди нарын өөрчилсөн хувилбар (2008), ¹⁷⁰ бөгөөд ISCO3-ны стандартаар баталгаажуулагдсан.

Заалтууд

1. 400 IP: Мэс заслын дараах¹⁷¹ болон Хоол боловсруулах замын өвчин, хеликобактер пилори Нр зэрэгт мөн нүүрний арьс нөхөн сэргээх, улайлт, батга, батгашил, булдруу зэрэгт уухаар хэрэглэнэ.
2. 400-600 IP: Шарх, трофик шарх, ил тод мөхлөгт түлэгдэлт.
3. 600 IP: Үтрээний салст бүрхэвч), шулуун гэдсээр хамрын хөндийн, трофик шархлааны эпителизацийн үе шатанд, хуйх болон арьс арчилгаанд
4. 800-1200 IP: Халдвараар хүндэрсэн шарх, шархлаа, буйлны үрэвсэл, цулцангийн үрэвсэл, энгийн хомхой, герпес зостер, псориазын шарх шархлаа

Анхааруулга: Зарим арилжааны бүтээгдэхүүний найрлагад гэмтэлгүй арьсанд зориулагдсан арьс нэвчих бодисыг сайжруулдаг: псориаз, вируст өвчин, арьсны мөөгөнцрийн халдвар, онихомироз, фурункулоз, буглаа.¹⁷²

Тосыг 4°C-ийн хөргөгчинд харанхуй шилэн саванд хадгалах ёстой. Хэт ислийн индекс дээр үндэслэсэн тунгийн хүрээ нь заагч бөгөөд одоогийн байгаа өгөгдлийн хураангуйд үндэслэсэн болно.¹⁷² Хэт ислийн чанарын тодорхойлолт хангалтгүйгээс одоо байгаа судалгаанууд буруу ойлголт төрүүлдэг. Тухайлбал:

- 1) Наранцэцгийн озонжуулсан тос (хэт ислийн хэмжээ 75 mEqO₂/кг –100 mEqO₂/кг) нь арьсны түлэгдэлтийн шинж тэмдгийг бууруулж, түлэгдэлтээс урьдчилан сэргийлэхэд болон гэмтлийн дараах нөсөөг багасгахад үр дүнтэй байдаг.¹⁷³
- 2) Хулганад арьсны цочмог шархыг эдгээх зорилгоор озонжуулсан гүнжидийн тосыг түрхэх нь хэт ислийн агууламжаар илэрхийлэгдэх бага (<1000 mEqO₂/кг) буюу их (3000 mEqO₂/кг) хоёулаа арьсны шархны эдгэрэлтийг удаашруулдаг болохыг харуулж байна. “Дунд” концентраци (ойролцоогоор 1500 mEqO₂ / кг) нь шархыг эдгээх харьцааг хурдасгахад хамгийн үр дүнтэй нөлөө үзүүлдэг.

Товчлол PV: хэт ислийн утга

3.3 Аюулгүй байдлыг хангах үүднээс хэрэглэхийг зөвлөдөггүй аргууд

3.3.1 *Озоны хийг венийн судсаар шууд тарих (DIV)*

Удаан дусаах шахуургаар 20хон мл хийхэд ч хийн эмболи үүсэх эрсдэлтэй тул үүнийг хэрэглэхийг хатуу хориглодог.⁴³ Тархины цус харвалтын хүндрэлүүд нь дотор чичрэх, ханиалгах энгийн шинж тэмдгээс эхлээд жихүүцэх мэдрэмж, толгой эргэх, харааны өөрчлөлт (амблиопи), гипотензи хямрал, тархины ишемийн шинж тэмдэг (мөчдийн парези) болон үхэлд хүргэнэ. Озоны хийг судсаар шууд тарьсны дараа хийн эмболизмын улмаас таван өвчтөн нас барсныг анхаарах нь чухал.^{91,92,175} Үүнээс гадна, псориазын эмчилгээнд озон хэрэглэх үед агаарын эмболизмын улмаас нас барсан тохиолдол бүртгэгдсэн байдаг.⁹⁴

Хүчилтөрөгчийн уусах чадвар 37°C-т, сийвэнгийн 100 мл ус тутамд ердөө 0.23 мл байдгийг анхаарах хэрэгтэй. Тиймээс цусны сийвэн нь хүчилтөрөгчийг хангалттай хурдан уусгаж чадахгүй бөгөөд энэ нь хийн эмболи үүсэхэд хүргэдэг.

Хулгана, туулайд хийгдсэн эмнэлзүйн өмнөх судалгаагаар DIV-ийн үр нөлөө судлан "Эмнэлзүйн өмнөх үр дүнгээс харахад озоныг шууд судсаар тарих нь маш их эрсдэлтэй бөгөөд шууд үхэлд хүргэж болзошгүй тул үүнийг хүмүүст хэрэглэх нь зөвтгөгддөггүй."⁴³ гэсэн дүгнэлтэд хүрсэн. Эмнэлгийн хувьд энэ аргын ашиг тусыг сайшаасан гурван тохиолдлын тайлан байдаг.¹⁷⁶⁻¹⁷⁸ Озон эмчилгээнд хэрэглэдэг нэр томъёоны хувьд нэг мөр биш байдгаас "судсаар озон хийх" гэсэн үгийг ашиглан ном зүйн хайлт хийхэд 15 судалгаа л гарч ирдэг.¹⁷⁹⁻¹⁹³

Гэсэн хэдий ч "материал болон арга аргачлалуудын хэсэгт озоныг судсаар хийх гэж гарч ирдэг ч нарийн уншаад үзэхэд энэ нь МАН болон O₃SS эмчилгээний аргуудыг дурдсан байдаг бөгөөд озоны хийг шууд венийн судсаар тарих талаар дурдаагүй байдаг.

Хий байдлаар озоныг шууд судсанд/DIV/ хийлгэж буй өвчтөнүүдэд хийн эмболийн шинж тэмдэг илт байна. Хүчилтөрөгч (O₃/O₂-ийн гол бүрэлдэхүүн хэсэг) эмболийн хий байж болох уу, үгүй юу гэсэн онолын хэлэлцүүлэг өрнөж байгаа ч энэ аргыг хэрэглэснээр нас барсан тухай мэдээлэл байдаг.^{91,92,175}

Цаашилбал, Ёс зүйн хороо эсвэл Байгууллагын хяналтын зөвлөлөөс зөвшөөрөгдсөн эмнэлзүйн дотоод туршилтаас бусад тохиолдолд нэгэнт аюулгүй бөгөөд үр дүнтэй нь батлагдсан МАН, MiАН, RI болон O₃SS зэрэг аргууд байхад өвчтөнд эрсдэлтэй арга ашиглах шаардлагагүй.

Озоныг судас хатаах зорилгоор ашиглах (энэ нь үр дүнтэй биш) нь хийг судсаар шууд явуулахыг хэлдэг ба түүнийг бас зөвлөдөггүй.

3.3.2 Тараагуур/артерийн/ судсанд тарих

Ёс зүйн хороо эсвэл Байгууллагын хяналтын зөвлөлөөс зөвшөөрөгдсөн эмнэлзүйн дотоод туршилтаас бусад тохиолдолд артерийн судсаар тарихыг хориглодог. Учир нь хийн эмболи үүсэх эрсдэлтэй.

3.4 ХОРИГЛОДОГ АРГУУД

Амьсгалын замаар

Амьсгалын замаар озон авах нь маш хортой тул түүнийг бүрэн хориглодог. Уушиг нь анатомийн болон биохимийн онцлогоос шалтгаалан озоны исэлдүүлэх нөлөөнд маш мэдрэмтгий байдаг.²¹ Нөгөөтэйгүүр, озоноор амьсгалж байх явцад вирусын эсэргүүцэх хариу урвалд оролцдог хэд хэдэн генүүд болон 1-р хэлбэрийн интерфероны зохицуулалт буурдаг. Тэгснээрээ цаашдаа урт хугацаанд опортунист халдварт өртөмтгий байдлыг нэмэгдүүлдэг.¹⁹⁴

3.5 Бүрэн зөвшилцөлд хүрээгүй хэрэглээний замууд

3.5.1 Үенд Озонжуулсан ус тарих

Үенд (голчлон Хятадад хэрэглэдэг) озонжуулсан усыг 22 мкг/Нмл-ээр тарих арга юм. Эмнэлзүйн туршилт судалгаануудаар энэхүү арга аргачлалын үр дүнтэй эсэхийг сайтар нотлох шаардлагатай байгаа. Эмнэлзүйн өмнөх судалгаагаар озонжуулсан усны тарилга эмчилгээний дараа хавдрын өсөлт дарангуйлагдсан байна учир нь энэ нь цусны нэвчилтийг нэмэгдүүлснээр хавдрын эсрэг эмийн эмчилгээнд нэмэр болдог гэж үзсэн байна.¹⁹⁵

3.5.2 Озонжуулсан глюкозын уусмалыг тарих

Озонжуулсан глюкозын уусмалыг хэрэглэх эмнэлзүйн болон эмнэлзүйн өмнөх нотолгоо байхгүй байна. Озон ба глюкозын хоорондох урвал нь үл мэдэгдэх альдегидийг үүсгэдэг бөгөөд энэ нь организмд хортой нөлөө үзүүлж болзошгүй юм.

3.5.3 Өндөр даралтаар олон замаар озон хийх ((НВОЗ)

Өндөр даралтаар озон хийх арга нь озон болон гепариныг маш өндөр тунгаар хэрэглэдэг. DIV-ийн нэгэн адил НВОЗ нь эмнэлзүйн өмнөх болон шинжлэх ухааны клиник нотолгоо байхгүй. Өвчтөнүүд эсвэл эмч нарын ярианаас үзэхэд гол гаж нөлөө нь: хараагүй болох, уушигны хямрал, өнгөтэй шээс гарах (цус задралын гематури) гэсэн байдаг. Гепарин нь озонтой хамтарснаар ялтас эсийн идэвхжил болон бөөгнөрлийг нэмэгдүүлдэг болох нь тодорхой.^{102,196} Тийм учраас МАН эмчилгээний үед гепарины оронд цитрат суурьтай антикоагулянт хэрэглэдэг.

